



Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

2015-2018

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ
ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ



АГУУЛГА

Мэндчилгээ	5
2018 оны онцлох үйл явдал	7
Гишүүнчлэл	8
Бодлогын өмгөөлөл	9
Хамтын ажиллагаа	10
Судалгаа	12
Арга хэмжээ	13
Шагнал, шалгаруулалт	15
Бизнес уулзалтууд	16
Үзэсгэлэн	17
Сургалт	19
Танхимын үйлчилгээ	20
Төсөл хөтөлбөр	21
Танхимын дотоодод хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	24
Хавсралт	26



МҮХАУТ-ын Удирдах зөвлөл, Тэргүүлэгч гишүүд, нийт гишүүн байгууллага, бизнес эрхлэгчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлэн, мэндчилж байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд бизнес эрхлэгчдийн эрх, ашгийг хамгаалах, бизнесийн орчныг сайжруулахад дуу хоолой болж, бодлогын өмгөөлөл, нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжин ажилласан гишүүн байгууллага, бизнес эрхлэгчиддээ юуны өмнө талархал илэрхийлье.

2014 онд МҮХАУТ-ын шинэ удирдлагын баг ажиллаж эхлэхэд, манай улсын эдийн засаг хямралтай, бизнес эрхлэгчид бухимдалтай байсан. 2013 оноос эхлэн гадаадын хөрөнгө оруулалт, дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрсний үнэ огцом унасан, гадаад валютын урсгал багасаж, төгрөгийн ханш суларсан, аж ахуйн нэгж хаалгаа барьж, Засгийн газар өндөр өрийн дарамтад орсон байдалтай манай улсын эдийн засаг үндсэндээ доройтон унасан байсан.

Энэ бүх нөхцөл байдлаас гарахад, бидний гол зорьсон ажил нь шинээр байгуулагдсан Засгийн газартайгаа хамтран эдийн засгийн зөв бодлого хэрэгжүүлж, тэр дундаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг батлуулахаас ажлаа эхлүүлж, 2014 оныг "Санхүүгийн шинэчлэлийг дэмжих жил" болгон зарлаж байсан.

Бизнес эрхлэгчдэд боломж олгох Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг 2015 оны 8 сараас хэрэгжүүлж эхлэхэд МҮХАУТ ихэд хичээл зүтгэл гарган ажиллаж, тэр дундаа хуулийн

хугацааг сунгуулахад голлон нөлөөлсөн юм. Үүний үр дүнд, 34.7 их наяд төгрөгийн хөрөнгө, орлогыг ил болгож, бизнес эрхлэгчид эдийн засгийн өршөөлийг хүртсэн.

Мөн НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 оны 1 сараас эхлэн хэрэгжүүлэхэд, МҮХАУТ бизнес эрхлэгчдэд таниулан сурталчлах, хэлэлцүүлэх ажлыг хийж, Засгийн газарт нөлөөлөн мэдэгдэл, уриалга гаргаж, буцаан олголтын механизмыг эхлүүлж чадсан юм.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд бизнес эрхлэгчид бид хямралтай эдийн засгаас эхлээд, Төрийн түшээдээ сонгох сонгууль, 3-н удаагийн Засгийн газрын шинэ бүтэц, улс төрийн зөрчилдөөн дунд цаашлаад Монгол Улсын Засгийн газраас ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт" нэгдэн орох зэрэг улс төр, эдийн засгийн томоохон өөрчлөлтөд бид хамтдаа зүтгэн ажиллаж ирлээ.

Бизнес эрхлэгчдийн томоохон төлөөлөл болсон МҮХАУТ энэ бүх шилжилт, өөрчлөлтөд өөрсдийн байр сууринд бат зогсож, бизнес эрхлэгчдэд дарамтгүй бизнесийн орчныг бий болгох, татварын шинэчлэлийг эхлүүлэх, эдийн засгийг солонгоруулах, хувийн хэвшлээ дэмжих, салбарын бодлогод анхааран ажиллаж ирсэн. Тухайлбал, Засгийн газраас ОУВС-гийн хөтөлбөрт нэгдэн орох нэрийдлээр 7 албан татварыг нэмэгдүүлэхийг эсэргүүцэн, шаардлага хүргүүлж, УИХ-ын Даргатай уулзан, зөвшилцөлд хүрч, Татварын шинэчлэлийн ажлыг эхлүүлж чадсан.

Мөн Татварын багц, ЖДҮ, Хөдөлмөр, Худалдаа, Зөрчил, Арбитрын тухай зэрэг бүхий л холбогдох хуулинд онцгой анхаарал өгч, УИХ-аар хэлэлцэгдэх хүртэлх бүхий л үйл явцад идэвхтэй ажиллалаа. Түүнчлэн бизнес эрхлэгчдийн нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын 78 байгууллагатай санамж бичиг байгуулсан бөгөөд анх удаа Улсын Их Хурлын Тамгын газар, ЗГХЭГ болон бусад голлох яамдтай санамж бичгийг байгуулсан нь Төр-Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах үйл явдал болсон юм.

Өнөөдөр бид Монгол Улсын эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан, ДНБ-ийн 70 гаруй хувийг бүрдүүлж, 800 гаруй мянган иргэдийг ажлын байраар хангаж, 2018 оны байдлаар нийт 8.2 их наяд төгрөгийг Улсын төсөвт бүрдүүлж, төлөвлөснөөс 29 хувь, ААНОАТ-ыг өмнөх оныхоос 33, ХХОАТ-ыг 22 хувиар давж төвлөрүүлэн, өндөр хариуцлагатайгаар ажиллаж байна.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд, санхүүгийн шинэчлэлийг эхлүүлэх, бизнесийн орчин нөхцөлийг сайжруулахад бизнес эрхлэгчдийн дуу хоолой болж, хамтдаа зүтгэн ажилласанд МҮХАУТ-ын Удирдах зөвлөл, Тэргүүлэгч гишүүд болон нийт гишүүд Та бүхэндээ талархал илэрхийлж, цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн,

МҮХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАЖАВ



МҮХАУТ-ын хамт олон, хамтран ажиллагч байгууллага, бизнес эрхлэгч Та бүхний туслалцаа, дэмжлэгтэйгээр өнгөрсөн 4 жилийн хугацаанд бизнесийн орчныг сайжруулах, бизнес эрхлэлтийг дэмжих, чадавхжуулах чиглэлээр үр бүтээлтэй олон ажлуудыг санаачлан, амжилттай хийж гүйцэтгэлээ.

Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор өнгөрсөн хугацаанд нийт 94 гаруй Төрийн байгууллагын хороо, зөвлөл, ажлын хэсэгт ажиллалаа. Үүнээс онцолбол, ЖДҮ, Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах салбарын яамны ажлын хэсэг, УИХ-ын Байнгын хорооны ажлын хэсэгт бизнес эрхлэгчдийн саналуудыг тусгуулсан. Засгийн газарт бизнес эрхлэгчдийн судалгаанд үндэслэсэн саналуудыг хүргүүлэх зорилгоор Монголын шилдэг эдийн засагч, хуульчдыг оролцуулсан “Эдийн засгийн бодлогын зөвлөл”, “Хуулийн бодлогын зөвлөл”-ийг байгуулан ажиллаж эхэллээ.

Мөн “Бизнесийн орчны судалгаа”, “Бизнес итгэлийн индекс” болон “Хүнд суртлын индекс судалгаа”-г шинэ аргачлалаар явуулж, үр дүнг Төрийн эрх баригчдад хүргүүлэн ажиллав. Төр-Хувийн хэвшлийн хэлэлцлийн шинэ механизмыг бий болгохоор олон жил идэвх, чармайлт гарган ажилласны үр дүнд, ЗГХЭГ-ын дэргэд ТХХ-ийн Зөвлөлдөх хороо байгуулан, ажиллаж байна. Бодлогын өмгөөлөл, нөлөөллийн ажлыг тоогоор авч үзвэл, нийт 62 хууль, бодлогын баримт бичиг, журмын

төслүүдийг боловсруулахад ажиллаж, 35 удаагийн хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. Мөн 2016 онд бизнес эрхлэгчдийг салбарын Сайд, бодлого боловсруулагч нартай уулзуулах “Business breakfast” өглөөний уулзалтыг шинээр санаачлан нийт 26 удаа, 4000 гаруй бизнес эрхлэгчдийг оролцуулан зохион байгууллаа.

Түүнчлэн бизнес эрхлэгчдийг дэмжинурамшуулах зорилгоор 2001 оноос эхлүүлсэн “ТОП-100 ААН”-ийн шагналын шалгаруулалтын аргачлалыг 2015 онд шинэчлэн өөрчилж, Засгийн газрын төлөөллийн байгууллагуудын албан мэдээлэлд үндэслэн, хамтран эрэмбэлдэг болсон нь олон улсын тавцан цаашлаад дэлхийн түвшинд компанийг тодорхойлох томоохон нэр хүнд бүхий шагнал болсон. Мөн 2015 оноос Шадар Сайдын ивээл дор “Үндэсний чанарын шагнал”-ыг санаачлан эхлүүлж, ААН, бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээндээ олон улсын стандартыг нэвтрүүлэх ач холбогдлыг сурталчлан таниулахад манлайлан ажиллаж байна.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд 9 улсын 60 гаруй үзэсгэлэнд 2500 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулж, 50 гаруй гадаад бизнес уулзалт, форумыг зохион байгуулжээ. Үүнээс онцолбол, Ази, Европын дээд хэмжээний бизнес уулзалт, Монгол-Хятадын анхдугаар ЭКСПО, Засгийн газар хоорондын бизнес уулзалт, Монгол Улсын Ерөнхий Сайд, салбарын сайд нарын БНХАУ, БНСУ, Япон улс дахь бизнес уулзалтуудыг амжилттай зохион байгууллаа.

Бид мөн дотооддоо бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг дэмжихээр 2015 онд “B2B уулзалт”-ыг санаачлан 29 удаа 2600 гаруй бизнес эрхлэгчийг оролцуулж, 2016 онд “Chamber bus хөтөлбөр”-ийг санаачлан нийт 14 аймгийн 402 бизнес эрхлэгчдийг тус аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй уулзуулж, мөн Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцах, үйлдвэрүүдээр зочлох, туршлага судлах, санал солилцох аяныг зохион байгуулсан. Мөн 2017 оноос “Entrepreneur Challenge хөтөлбөр”-ийг санаачлан, нийт 9 аймагт 950 бизнес эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудад мэдлэг, чадвар олгох сургалт, семинарыг зохион байгуулж, мөн богино, дунд хугацааны сургалтанд 10000 орчим бизнес эрхлэгчдийг хамрууллаа.

2015 онд манай хамт олон 55 жилийн ойгоороо Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-гоор шагнуулсан.

Энэхүү амжилтаа бататгаж, бизнес эрхлэгчдийн томоохон төлөөллийн хувьд дотоодын үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор хоёр томоохон төслийг амжилттай хэрэгжүүллээ. Танхимын хамт олон 2015-2018 онуудад чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дэлхийд нэр хүндтэй Швейцарын “SGS” компаниас баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа.

Мөн Олон Улсын Худалдааны Төвийн "Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг" төсөлд хамрагдаж, үр дүнд нь дэлхийн бусад танхимуудтай харьцуулсан өөрсдийн үнэлгээг 2016 оны үзүүлэлтээс 25 хувиар сайжруулж, бүх үзүүлэлтийг дунджаас дээгүүр болгон, сул талгүй болж чадсан юм.

Түүнчлэн 2015 оноос эхлэн гишүүдийн мэдээллийг төвлөрүүлэх, санал гомдлыг үйл ажиллагаандаа тусгах, хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн үйлчилгээ үзүүлэхээр "Мэдээлэл үйлчилгээний нэгдсэн систем"-ийг 2018 онд бүрэн ажиллагаанд орууллаа.

Бизнес эрхлэгчдээ чадавхжуулах, экспортыг нэмэгдүүлэхээр 2016 оноос Азийн сан, 2017 оноос

Дэлхийн Банкны "Экспортыг дэмжих төсөл", 2018 оноос Европын Холбооны "Худалдааг дэмжих төсөл"-үүдтэй хамтран экспортлогчдыг чадавхжуулах, сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 2019 оноос эхлэн Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран бизнес эрхлэгчдэд бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх "Нэг цэгийн үйлчилгээ"-г Танхим дээр нээсэн.

Бид олон улсад нэр хүндээ нэмэгдүүлж, өөрсдийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулсны үр дүнд Олон Улсын байгууллагаас нэр хүндтэй олон шагналуудыг хүртсэн. Тухайлбал, МҮХАҮТ, Германы Танхимын хамтран хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй "Хонины ноос болон чацарганы нэмүү

өртгийн сүлжээг дэмжих төсөл"-ийг "Олон Улсын Худалдааны Төв"-өөс өндрөөр үнэлэн, Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж буй байгууллага"-аар онцолж, шагнал хүртсэн.

Танхимын нийт 3395 гишүүн байгууллага, харилцагчид, түншүүд, бизнес эрхлэгч Та бүхэнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд бидний үйл ажиллагааг дэмжин, хамтран ажилласанд Танхимын гүйцэтгэх удирдлагын багын хамт олон, нийт 105 ажиллагсдын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Дарга

М.Оюунчимэг



УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

1. АПУ ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг
2. Арж капитал ХХК-ийн ерөнхий захирал Х.Мөнх-эрдэнэ
3. Барилга эм эн ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батсүх
4. Барс групп ХХК-ийн ерөнхий захирал Ч.Амарбаатар
5. Бишрэлт Холдинг ХХК-ийн ТУЗ-ийн дарга А.Ариунболд
6. Бодь интернэшнл ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Амундра
7. Бридж групп ХХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Батзориг
8. БСБ сервис ХХК-ийн ерөнхий захирал Б.Жаргалсайхан
9. Витафит инвест ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Болорсайхан
10. Ган Хийц ХК-ийн ерөнхий захирал М.Даваасүрэн
11. Говь ХК-ийн үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа
12. Гоёо ХХК
13. Голомт банкны ерөнхийлөгч Г.Ганболд
14. Гурван гал трейд ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Ганхуяг
15. Жем интернэшнл ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ойгонгэрэл
16. Женерал электрик Интернэшнл ХХК-ийн менежер Б.Жавхлан
17. Жүр үр ХХК-ийн хүний нөөцийн захирал Б.Мөнхзул
18. Интерактив Би Ай ХХК-ийн ерөнхий захирал Ч.Чимиддорж
19. Коёотэ ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бямбасайхан
20. М Си Эс холдинг ХХК гүйцэтгэх захирал Л.Гантөмөр
21. Макс группийн ерөнхийлөгч Д.Ганбаатар
22. Мишээл группийн гүйцэтгэх захирал Р.Олонбаяр
23. Мо Тү Өв ХХК-ийн ерөнхий захирал З.Түмэн-Өлзий
24. Мобиком корпораци ХХК-ийн олон нийт, хамтын ажиллагааны газрын захирал Д.Уянга
25. Мон Фрэш группийн ерөнхийлөгч Т.Насанхүү
26. Монгол Глобал ХХК-ийн ерөнхий захирал Б.Ганбаяр



27. Монголын Үндэсний Цирк ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Пүрэвбадам
28. Монланс ХХК-ийн ерөнхий захирал Д.Баасан
29. Монос группийн гүйцэтгэх захирал Х.Ананд
30. Мөнхийн үсэг ХХК-ийн ерөнхий захирал Д.Ганбат
31. Наран трейд ХХК-ийн ерөнхий захирал Д.Удвал
32. НВЦ ХК-ийн ерөнхий захирал Ц.Баатарбилэг
33. Номин холдинг ХХК-ийн ерөнхийлөгч Ш.Баярсайхан
34. Ноосон зангилаа дундын хоршооны дарга Ц.Цэнд-Аюуш
35. Нью жуулчин турс ХХК-ийн ерөнхий захирал Ш.Нэргүй
36. ОБ пластик ХХК-ийн ерөнхий захирал Ж.Отгонбаяр
37. Оюу Толгой ХХК-ийн ГХОНХГ-ын ерөнхий менежер Ж.Сүнжидмаа
38. Өгөөж-Чихэр боов ХХК-ийн ерөнхий захирал С.Түмэнгэрэл
39. Ремикон ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Хашчимэг
40. Содмонгол группийн ерөнхийлөгч Ц.Анандбазар
41. Сүү ХК-ийн гүйцэтгэх захирал М.Мандхай
42. Төрийн банкны гүйцэтгэх захирал Г.Дөлгөөн
43. Туушин ХХК-ийн ерөнхий захирал Н.Зоригт
44. Ханбогд кашмер ХХК-ийн ерөнхий захирал Ч.Ганцэцэг
45. Хас банкны ерөнхий захирал Г.Амартүвшин
46. Хатан сүлжээ ХХК-ийн ерөнхий захирал Б.Бадамханд
47. Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэл
48. Энсада холдинг ХХК-ийн ерөнхий захирал Ө.Болдсайхан
49. Юнител ХХК-ийн захиргаа, хүний нөөцийн асуудал эрхэлсэн захирал Ц.Азжаргал
50. UFC группийн ерөнхий захирал О.Амартүвшин
51. Архангай аймаг дахь ХАУТ-ын дарга Ц.Жамбалсүрэн
52. Баян-Өлгий аймаг дахь ХАУТ-ын дарга Х.Муратай
53. Баянхонгор аймаг дахь ХАУТ-ын дарга Г.Энхтүвшин
54. Булган аймаг дахь ХАУТ-ын дарга Д.Оюунгэрэл
55. Говь-Алтай аймаг дахь ХАУТ-ын дарга Л.Батжаргал
56. Говьсүмбэр аймаг дахь ХАУТ-ын дарга Б.Цэцгээ
57. Дархан аймаг дахь ХАУТ-ын дарга С.Мэндхүү
58. Дорнод аймаг дахь ХАУТ-ын дарга Э.Адъяа
59. Дорноговь аймаг дахь ХАУТ-ын дарга Ш.Отгонбаяр
60. Дундговь аймаг дахь ХАУТ-ын дарга Б.Ням
61. Завхан аймаг дахь ХАУТ-ын дарга Г.Бадамхатан
62. Орхон аймаг дахь ХАУТ-ын дарга М.Ганбат
63. Өвөрхангай аймаг дахь ХАУТ-ын дарга Б.Ууганбаяр
64. Өмнөговь аймаг дахь ХАУТ-ын дарга П.Батбаяр
65. Сүхбаатар аймаг дахь ХАУТ-ын дарга С.Батболд
66. Сэлэнгэ аймаг дахь ХАУТ-ын дарга Б.Ундрах
67. Төв аймаг дахь ХАУТ-ын дарга Ч.Мөнхбат
68. Увс аймаг дахь ХАУТ-ын дарга С.Сэржим
69. Ховд аймаг дахь ХАУТ-ын дарга Б.Ганзориг
70. Хөвсгөл аймаг дахь ХАУТ-ын дарга Ж.Сарангэрэл
71. Хэнтий аймаг дахь ХАУТ-ын дарга Д.Батболд

- Дарга М.Эрдэнэжаргал /ММНБИнститут/
- Гишүүн Б.Осоргарав /Улаанбаатар Аудит ХХК/
- Гишүүн Э.Нинждулам /Юдентакс тин аудит ХХК/
- Гишүүн Д.Цэцэгсүрэн /Тэгш хэм групп/
- Гишүүн И.Гүррагчаа /Хүлэгт хүннү аудит ХХК/
- Гишүүн Г.Хонгор /Эрсдлийн шийдэл ХХК/
- Гишүүн Б.Батхуяг /ССАЖЯам/

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Дарга
М.Оюунчимэг




Орлогч дарга
М.Сарандаваа



Ерөнхий нарийн бичгийн дарга
Э.Оюунтөгш



БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



2015 он - Санхүүгийн шинэчлэлийг дэмжих жил

2016 он - Засаглалыг дэмжих жил

2017 он - Худалдааг хөнгөвчлөх жил

2018 он - Бизнесийн тогтвортой орчныг дэмжих жил

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

- Стратегийн зорилт 1: Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилт 2: Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилт 3: Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилт 4: Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилт 5: Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилт 6: Танхимын засаглал, менежментийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх



- МҮХАУТ-ын 55 жилийн ойг 2015 оны 7-р сарын 3-ны өдөр гишүүд, бизнес эрхлэгчид, хамтран ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн.
- МҮХАУТ-ын хувийн хэвшилд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 7-р сарын 8-ны өдрийн 128 дугаар зарлигаар олгосон "Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон"-гоо хүлээн авсан.
- Монгол Улсын Засгийн газар, МҮХАУТ хамтран шалгаруулдаг Монгол Улсын ТОП-100 ААН-ийн шалгаруулалтыг Олон улсын "Фортун" сэтгүүлийн аргачлалын дагуу шинэчлэн өөрчилж 2015 оноос Сангийн Яам, ТЕГ, ГЕГ, НДЕГ, ҮСГ, ОӨГ, СЗХ зэрэг байгууллагын статистик мэдээлэлд үндэслэн ААН-ийн тухайн жилийн орлого, улсад төлсөн татвар, нийгмийн даатгал төлсөн ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ гэсэн үндсэн 5 үзүүлэлтээр эрэмбэлэх болсон.
- 2015 оноос хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилгоор "Үндэсний чанарын шагнал"-ыг шилдэг бүтээгдэхүүн, шилдэг үйлчилгээ, шилдэг байгууллага гэсэн номинациар Стандартчилал хэмжил зүйн газартай хамтран олгох болсон.
- Хүний нөөцийн менежментийн үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх, цаасан суурьтай бичиг баримтыг багасгах, ажилтнуудын мэдээллийг төвлөрүүлж автоматжуулах, гүйцэтгэх удирдлагыг түргэн шуурхай мэдээллээр хангах, бодит өгөгдөлд суурилсан оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор Хүний нөөцийн Green HR системийг 2015 онд нэвтрүүлсэн.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, хэлэлцлийг хөгжүүлэх, бизнес эрхлэгчдийн санал, санаачлагыг төрд уламжлах зорилгоор 2016 оноос Улсын Их Хурлын гишүүд, салбарын сайд, холбогдох төрийн байгууллагуудын дарга нарыг оролцуулсан "Business breakfast" уулзалтыг санаачлан зохион байгуулсан.
- МҮХАУТ-аас Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн судалгааны болон хэлэлцээрийн шатанд ажиллаж, 2016 онд хэрэгжиж эхэлснээс хойш нийт 80 гаруй ААН-ийн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнд 1599 ширхэг гарал үүслийн гэрчилгээг олгоод байна.
- 2016 онд Монгол Улсаас нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын "Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэхээр МҮХАУТ-аас "Худалдаа хөнгөвчлөх үндэсний хороо"-нд орж ажиллан, худалдааг хөнгөвчлөх хөтөч зургийг хамтран боловсруулав.
- 2016 онд МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран Монголын бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээнүүд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог тодорхойлоход чиглэсэн "Бизнесийн орчны судалгаа"-г 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн 1828 аж ахуй нэгжийг хамруулан явуулж судалгааны тайланг нийтэд танилцуулсан.
- 2017 онд бизнесийн хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд хамтран ажиллах зорилгоор Улсын Их Хурлын Тамгын газартай хамтын ажиллагааны санамж бичгийг төрийн бус байгууллагуудаас анх удаа байгуулсан.
- Бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төр засагт хүргэх, тогтвортой хамтын ажиллагааг бий болгох, МҮХАУТ-ын бодлогын өмгөөлөл, нөлөөллийн ажилд зөвлөмж, чиглэл өгөх зорилгоор Танхимын дэргэд Монголын тэргүүлэх эдийн засагчдаас бүрдсэн "Эдийн засгийн бодлогын зөвлөл" -ийг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 11-р сард байгуулсан.





- Монгол улсад төр хувийн хэвшлийн хэлэлцлийн механизмыг хөгжүүлэх зорилгоор Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 320 тоот тушаалаар Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэд Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо байгуулагдаж МҮХАҮТ хувийн хэвшлийг төлөөлөн орсон.
- 2016 онд Ази Номхон Далайн Орнуудын Худалдаа Аж үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбооны дэд ерөнхийлөгчөөр МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг сонгогдсон.
- Гишүүдэд чиглэсэн стратегийг дэвшилтэт технологи ашиглан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сан дээр үндэслэн дүн шинжилгээ, анализ хийх, гишүүн болон үйлчлүүлэгчдийн талаарх бүх мэдээллийг төвлөрүүлэх, гишүүдээс ирсэн санал гомдлыг үйл ажиллагаандаа бодитоор тусгах, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх зорилгоор "Мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн систем"-ийг 2015-2018 онуудад үе шаттайгаар амжилттай нэвтрүүлэв.
- 2018 онд бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай төрийн бус байгууллагуудаас анх удаа хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.
- Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ-уудын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвили Монгол улсад 2018 онд айлчилсан.
- 2018 онд Олон Улсын Худалдааны Төв (International Trade Center)-өөс МҮХАҮТ, ГХАҮТХ хамтран хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй "Хонины ноос болон чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл"-ийг НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд их хувь нэмэр оруулж буй байгууллага"-аар онцолж шагнал олголоо.
- МҮХАҮТ үйл ажиллагаандаа ISO 9001 олон улсын чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх төслийг 2016-2018 онуудад амжилттай нэвтрүүлж, 2018 онд Швейцарийн Женевт төвтэй "SGS" компаниас баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан.
- 2016 онд Олон Улсын Худалдааны Төв (International Trade Center)-өөс МҮХАҮТ-ын үйл ажиллагаан дээр Бэнчмаркинг буюу харьцуулсан үнэлгээг хийсэн. Тус үнэлгээний үр дүнд үндэслэн үндсэн 4 зорилт бүхий Танхимын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг төслийг 2016-2018 оны хугацаанд хэрэгжүүлснээр 2018 онд тус байгууллагаас дахин хийсэн харьцуулсан үнэлгээгээр 57,84% гэсэн нь 2016 оны үнэлгээтэй харьцуулахад 25 гаруй хувиар өссөн үзүүлэлтэй байсан.
- Олон Улсын Худалдааны Төв (International Trade Center)-өөс 2017-2018 онд хэрэгжүүлсэн МҮХАҮТ-ын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг төслийн хүрээнд үр дүнд суурилсан бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, танхимын 6 стратегийн зорилтын 13 шалгуур үзүүлэлт, газар нэгжийн түвшний зорилтуудын 45 шалгуур үзүүлэлт, ажилтны түвшний зорилтуудын 425 шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан гаргаж гүйцэтгэлийн хэмжигдэхүйц тогтолцоог бүрэн бүрдүүлсэн.
- 2004 оноос явуулсан "Хүнд суртлын индекс" судалгааг төрийн үйлчилгээний цаг хугацаа, зардал, баримт бичгийн тоо зэрэг үзүүлэлтүүдэд тулгуурлан бодитой тооцож гаргах зорилгоор Азийн сангийн дэмжлэгтэйгээр судалгааны аргачлалыг шинэчлэн боловсруулж Улаанбаатар хот болон орон нутгийн 1910 аж ахуйн нэгжийг хамруулан төрийн 54 байгууллагын давхардсан тоогоор 2009 үйлчилгээг үнэлүүлсэн.

НӨЛӨӨЛӨЛ

Стратегийн зорилт 1. Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх


НӨЛӨӨЛӨЛ

Бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төрийн эрх барих дээд байгууллага, төрийн болон засаг захиргааны бүх шатны байгууллагуудад хүргэх үр дүнтэй механизмыг бий болгох, хамтран ажиллах чиглэлээр хууль эрх зүй, бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт хороодод бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, танхимаас төлөөлөн үр дүнтэй оролцоход онцгой анхаарч ажилласан.

Мөн танхимын дэргэдэх зөвлөлүүдийг оновчтой зохион байгуулж, тэдгээрийн бодлогын өмгөөлөл явуулах чадавхийг нэмэгдүүлэх тодорхой ажлуудыг Европын холбооны TRAM-худалдааг дэмжих төслийн хүрээнд 2019-2020 онуудад хэрэгжүүлэхээр төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, үйл ажиллагааг эхлүүлээ.

Бодлогын нөлөөллийг сайжруулахад гаргасан ахиц дэвшил

Бизнесийг орчныг сайжруулах, ялангуяа хууль эрх зүйн орчныг таатай болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын Тамгын Газартай 2017 оны 2 дугаар сарын 15-нд, Монгол улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай 2018 оны 7 дугаар сарын 6-нд тус тус санамж бичиг байгуулсан нь нөлөөллийн чиглэлээр хийсэн томоохон алхам боллоо. Мөн энэ чиглэлээр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамтай 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр, Үндэсний Хөгжлийн Газартай 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдөр тус тус хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж хамтран ажиллаа.



Монгол Улсын Их Хурлын Тамгын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд УИХ-ын Даргын орон тооны бус зөвлөхөөр МҮХАҮТ-ын Тэргүүлэгч гишүүн, Барс группийн Ерөнхийлөгч Ч.Амарбаатарын нэрийг дэвшүүлж, томилуулсан ба УИХ-ын чуулганд өргөн барих, хэлэлцүүлэх НББСШУ-ны Байнгын хорооны Хөдөлмөрийн хуулийн дэд ажлын хэсэг, Эдийн засгийн Байнгын Хорооны Банкны болон Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн дэд ажлын хэсэг, Төсвийн Байнгын хорооны Татварын багц хуулийн дэд ажлын хэсэг, БОХХАА-н Байнгын хорооны Баяжуулсан хүнсний тухай хуулийн дэд ажлын хэсэгт тус тус Танхимын удирдлага болон Тэргүүлэгч гишүүд орж ажилласан.

Мөн Монгол улсад Төр-Хувийн хэвшлийн хэлэлцлийн механизмыг хөгжүүлэх зорилгоор Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2017 оны 320 тоот тушаалаар Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэд "Төр-Хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо" байгуулагдсан ба үүнд МҮХАҮТ хувийн хэвшлийн төлөөлөн тэргүүлэн ажиллаж байна.

Гадны зөвлөл, хороо, ажлын хэсгүүдэд оролцож ажилласан байдал

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 94 хороо, зөвлөл, комисст гишүүнээр төлөөлөн орж ажлын хэсэгт ажилласан. Үүнээс 49 хороо, удирдах болон ерөнхий зөвлөл, 45 ажлын хэсэгт орж ажиллаж байна. (Хавсралт 1)

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажил олгогчийг төлөөлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ба УИХ-ын Байнгын хорооны ажлын хэсэгт хоёр жил гаруй ажиллаж, бизнес эрхлэгчидтэй олон удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 80 гаруй саналыг хүргүүлж, 20 гаруй саналыг хуулийн төсөлд тусгуулсан. Мөн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн



төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж хуульд зарчмын зөрүүтэй саналыг гаргаж, ажлын хэсэг, УИХ-ын холбогдох Байнгын хороо болон УИХ-ын гишүүдэд хүргүүлэн ажиллаж байна.

Танхимын дэргэдэх зөвлөлүүд:

Танхимын дэргэдэх зөвлөлүүд нь Бизнес эрхлэгчид салбарын болон тодорхой асуудлаар санаа бодлоо солилцох, бодлогын өмгөөллийн чиглэлээр нэгдэх, салбарын төрийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой. Олон Улсын Худалдааны Төв (ИТС)-ийн экспертүүдийн зөвлөсний дагуу зөвлөлүүдийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, тодорхой салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаатай давхцаж байгаа байдлыг арилгасан. МҮХАУТ-ын бодлогын өмгөөллийн үйл ажиллагааг сайжруулах, танхимаас гаргаж буй хууль, эрх зүйн баримт бичгийг эрх зүйн хувьд зөв, үндэслэлтэй гаргах хэрэгцээ шаардлагыг үндэслэн шинээр Эдийн засгийн бодлогын зөвлөл, Хуулийн бодлогын зөвлөлийг байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бизнесийн 20 зөвлөл Танхимын дэргэд ажиллаж байна. (Хавсралт 2)

Танхимын дэргэдэх зөвлөлүүд 2015-2018 онуудад бодлогын өмгөөлөл, бизнесийг дэмжих чиглэлээр мөн салбарын болон тодорхой асуудлаар бизнес эрхлэгчдийн чадавхийг сайжруулах олон ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээ. Тухайлбал:

Эдийн засгийн бодлогын зөвлөл:

- Зөвлөлийн гишүүд 2017 оны 12 сард Төв банкны тухай, Банкны тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэх Эдийн Засгийн Байнгын Хорооны ажлын хэсгийн ахлах УИХ-ын гишүүн Б.Жавхлантай уулзаж, тус хуулийн талаар хэлэлцэн, саналаа нэгтгэж Эдийн Засгийн Байнгын Хороо болон УИХ-ын гишүүнд хүргүүлэв.
- Татварын багц хуулийн төсөлд саналыг, судалгааны хамт боловсруулж, Монгол Улсын Ерөнхий Сайд, Сангийн Сайдад хүргүүлэв.
- ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулж, УИХ-ын гишүүдэд хүргүүлэв.
- Зөвлөлөөс гаргасан "Сүүлийн 27 жилийн байдлаар татварын шатлал, эдийн засгийн нөхцөл байдлын харьцуулалт шинжилгээ"-нд үндэслэн УИХ-ын Дарга, гишүүдэд хандан ААНОАТ-ын хуулийг УИХ-аар дахин хэлэлцүүлэх тухай мэдэгдэл гаргав.
- 2017, 2018, 2019 оны улсын төсөвт дүн шинжилгээг төсвийн орлого, зарлагын дэлгэрэнгүй байдлаар ЭЗБЗ-ийн гишүүн Ж.Дэлгэрсайхан хийж гүйцэтгэв. Мөн зөвлөлийн гишүүд 2019 оны Улсын төсөвт өгөх зарчмын саналыг хэлэлцэн, саналыг судалгааны хамт УИХ-ын Дарга, Байнгын хороодын дарга болон УИХ-ын гишүүдэд хүргүүлэв.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл:

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөлөөс "Нэг бүс нэг зам" Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын хамтын ажиллагааны форумыг Монгол-Өвөр Монголын Бизнесийн Ерөнхий

Холбоо, ӨМӨЗО-ны Олон Улсын Худалдааг Дэмжих Хорооны УБ дахь төлөөлөгчийн газартай хамтран 2018 оны 12 дугаар сард зохион байгууллаа.



- Монголын аялал жуулчлалын холбоо, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгтэй хамтран "Аялал жуулчлалын салбар дахь зохиогчийн эрхийн асуудал" сэдэвт ээлжит семинар, уулзалтыг 2018 оны 5 сард зохион байгуулсан.
- Үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээний үеэр МУ-ын аялал жуулчлалын салбарын мэргэжлийн байгууллагуудад тулгардаг нийтлэг бэрхшээл болох гадаадын жуулчдад олгодог билетийн хүрэлцээний санал гомдлын дагуу БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат, Нийслэлийн засаг бөгөөд УБ хотын захирагч С.Батболд нарт албан бичиг хүргүүлж тодорхой үр дүнд хүрсэн.

Ноос ноолуурын зөвлөл:

- Ноос ноолууран бүтээгдэхүүнийг экспортонд гаргахад Хөдөө Аж Ахуйн Биржээр арилжаалагдсан байна гэж хуулинд оруулсантай холбоотойгоор ноос ноолууран бүтээгдэхүүн экспортлогч компаниудад торгууль ноогдуулсан тул Ноос ноолуурын зөвлөлөөс ХААБ-ийн тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналуудыг боловсруулж ЗГХЭГ-ын "Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл"-ийн дэргэд байгуулагдсан Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороонд хүргүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд ХААБ болон аж ахуйн нэгжүүд эвлэлийн гэрээг байгуулсан.

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл:

- Бичил бизнесийн хүрээнд гарч буй нийтлэг хууль эрх зүйн асуудлыг тодорхойлох, хуулийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой санал хүсэлтийг тодорхойлох, цаашид хүрч ажиллах аргачлал, харилцаа холбоог тодруулах зорилгоор "Бичил бизнес эрхлэгчдийн хууль эрх зүйн асуудлыг тодорхойлох судалгаа" хийсэн.

Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл:

- Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөлөөс 2017 оноос эхлэн 2 жил дараалан ОУ-ын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан жендерийн эрх тэгш байдлын төлөө хонх цохих "Ring the Bell" арга хэмжээг Монголын хөрөнгийн бирж, IFC болон бусад байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулав.





- НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact)-ний ажлын албаны үүргийг гүйцэтгэж байна.
- АНУ-ын ЭСЯ, Канад улсын ЭСЯ, БНСУ-ын ЭСЯ, Канадын засгийн газрын дэмжлэгтэй Uniterra төсөл зэрэг байгууллагуудтай хамтран компаниудад КНХ-ын чиглэлээр мэдээлэл олгох сургалт, уулзалт хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулж, давхардсан тогоор 300 орчим бизнес эрхлэгчдийг хамруулав.
- АТГ-тай хамтран Авлигын эсрэг үндэсний форум, Авлигын эсрэг удирдлагын тогтолцооны ISO37001-ийн сургалтыг амжилттай зохион байгуулав.
- НҮБ-ын Хүүхдийн сан, Гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газартай хамтарсан “Хүүхэд хамгааллын баримт бичиг боловсруулах” ажлын хэсгийн хүрээнд хийсэн судалгааны ажлын хэсэгт ажиллаж, холбогдох 2 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- Компанийн засаглалын үндэсний төвтэй хамтран 2016 оны ТОП-100 ААН-ийн дунд засаглал, КНХ-ын судалгаа хийж, үр дүнг нэгтгэн товч тайлан гаргав.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл:

- Ази Номхон Далайн Бүс Нутгийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгчийн Монгол Улс дахь албан ёсны айлчлалын хүрээнд Танхим болон Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан “Ази Номхон Далайн бүс нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулган”-ыг Улаанбаатар хотноо анх удаа 2018 оны 9 сарын 6-7 нд зохион байгууллаа. Энэхүү чуулганд Ази Номхон Далайн Бүс Нутгийн болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ХАҮТ-ын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүд хүрэлцэн ирж, нийт 200 орчим эмэгтэй бизнес эрхлэгчид оролцсон.



- 2017, 2018 онуудад МҮХАҮТ-ын тус зөвлөлөөс IWEC ашгийн бус Олон улсын байгууллагаас амжилттай бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олгодог “The International Woman Entrepreneurial Challenge” шагналд Монголын шилдэг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэвшүүлж, шагнал хүртлээ.

1. Би Эф Эй Эс ХХК-ны гүйцэтгэх захирал Л.Болормаа
2. Траст трейд ХХК-ны гүйцэтгэх захирал Т.Сансармаа
3. Жүр-Үр ХХК-ийн захиргаа, хүний нөөцийн газрын захирал Б.Мөнхзул
4. “Ялгуун аксесорис” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Өлзиймаа
5. “Сноу Филдс” компанийн ерөнхий менежер Д.Нарантуяа
6. “Урбан” брэндийг үүсгэн байгуулагч “Денимон” ХХК-ийн ерөнхий захирал Д.Тунгалаг нар хүртлээ.



- БНХАУ-ын Гуанжоу хотноо 2018 оны 11 сард зохион байгуулагдсан “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дээд хэмжээний олон улсын форум”-д Зөвлөлийн гишүүд оролцов.
- 2018 оны 9 дүгээр сард 21 аймгийн 90 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг оролцуулан “Орон нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулав.
- Зөвлөлөөс “Эмэгтэй захиралтай ААН-үүдэд тулгарч буй сорилт, бэрхшээл тэдгээрийг даван туулах арга замууд” үндэсний хэмжээний судалгааг санаачлан 1000 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээс авав.
- Зөвлөлөөс анх удаа 50-н бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг танилцуулсан “Business women directory-2018” номыг англи, монгол хэлнээ хэвлэн гаргасан.
- УИХ-ын гишүүн Б.Ундармаатай уулзаж ЖДҮ-ийн тухай хуулийн талаар хэлэлцэн, саналыг нэгтгэн УИХ-ын эмэгтэй гишүүд, холбогдох Байнгын хороонд хүргүүлэв.
- Хөдөлмөр, Татварын багц, ЖДҮ-ийн тухай хууль, ЖДҮХСангийн болон бусад салбарын бодлогын асуудалд зөвлөлийн гишүүд хүчтэй байр сууриа илэрхийлэн холбогдох УИХ-ын гишүүд, Байнгын хороо, Засгийн газарт саналаа хүргүүлэн ажиллав.





Сэргээгдэх эрчим хүчний зөвлөл:

- Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (IRENA)-тай хамтран Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн ТЭЗҮ хийх сургалт зохион байгуулав.
- Сэргээгдэх эрчим хүчний холбоотой хамтран Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форумыг зохион байгуулсан.

Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл:

- Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын төрийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа “Хяналтын хуудас”-ыг салбарын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хяналт шалгалтын ажлыг нээлттэй, ил тод байлгах зорилгоор Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран “Төрөөс экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний талаар баримталж буй бодлого” түүний хэрэгжилтийн тухай хэлэлцүүлгийг 2016 оны 6 сард зохион байгуулсан.
- Монгол Улсын Засгийн Газраас баримталж буй 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2016 оны 5 сард “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд болон үйлдвэрлэгчдийн чуулган”-ыг зохион байгуулсан
- 2018 оны 6 сард “Малын яс, тос боловсруулж импортыг орлох, экспортыг дэмжих нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх кластерыг хөгжүүлэх боломж” зөвлөгөөнийг зохион байгуулав
- 2017 оны 5 сард “Эрүүл хүнс-бидний сонголт” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан.

Инноваци ба Гарааны бизнесийг дэмжих зөвлөл:

- Инновацийн долоо хоногийн хүрээнд 2018 оны 5 сард “Шинжлэх ухаан-боловсрол-төр-бизнесийн түншлэл” семинарыг зохион байгуулсан.
- 2018 оны 5 сард “Инновацийн түншлэл-хөгжлийн гарц” чуулганыг зохион байгуулсан.
- “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, БНХАУ-ын Шинжлэх Ухаан, Технологийн Яам хоорондын Шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд 2018 оны 7 сард “Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа-2018” үзэсгэлэнг зохион байгуулсан.

Чөлөөт бүс, хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл:

- 2015 оны 4 сард Замын Үүд чөлөөт бүс хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт
- 2015 оны 6 сард “Алтанбулаг-2015” Эдийн засгийн чуулга уулзалт
- 2015 оны 10 сард “Чөлөөт бүсүүдийн хоорондын тээвэр ложистикийн асуудал, ирээдүйн хөгжил” сэдэвт уулзалт

- 2015 оны 11 сард “Халх гол чөлөөт бүс” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- 2015 оны 11 сард Хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судлан, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулав.
- 2016 оны 5 сард Алтанбулаг-2016 олон улсын форум, үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.
- Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Экспортыг дэмжих зөвлөл:

- Монгол улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Монгол Экспорт” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт 2017-2018 онуудад орж ажилласан. Зөвлөлөөс өгсөн 2 санал тус хөтөлбөрт орон дэмжигдэн батлагдсан. Тухайлбал зөвлөлийн гишүүдийн хурлаар санал болгосон Монгол улсын хэмжээгээр экспортын үндэсний өдөртэй болох, экспортын шилдэг бүтээгдэхүүний шагнальтай болох саналыг тухайн хөтөлбөрт тусгуулсан.
- Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөлтэй хамтран 2017-2018 оны хооронд 5 удаагийн сургалт зохион байгуулсан.
- 2018 оны 10 сард ГХЯ-тай хамтран “Экспортын тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Худалдааг хөнгөвчлөх, тээвэр ложистикийн зөвлөл

- 2016 оны 3 дугаар сард “Худалдаа тээврийн салбарын хамтарсан уулзалт”-ыг зохион байгуулав.
- Монголын ложистикийн холбоо, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуультай хамтран 2016 оны 4 дүгээр сард “Худалдаа тээврийг хөнгөвчлөхөд ложистикийн үүрэг” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн уралдаан, хэлэлцүүлэг, танилцах аян, сургалт, үзэсгэлэн зохион байгуулсан.
- Монголын тээвэр зуучийн нэгдсэн холбоотой хамтран “Тээвэр ложистикийн анхан шатны сургалт”-ыг зохион байгуулав.

Сав баглаа боодлын зөвлөл:

- МҮХАҮТ-ын дэргэдэх Хятадтай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл, МҮХАҮТ-ын дэргэдэх сав баглаа боодлын зөвлөл хамтран оролцсон Гуанжоу хотын 25 дахь удаагийн Хятадын Олон Улсын сав баглаа үйлдвэрлэлийн үзэсгэлэн /Sino-Pack2018/, 2018 оны 3 дугаар сарын 10-12.
- ХХААХҮЯ-тай хамтран зохион байгуулсан МУ-д үйлдвэрлэсэн дотоодын сав баглаа боодлыг үйлдвэрлэл, үйлчилгээндээ хэрэглэгч нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах арга хэмжээ, 2018 оны 12 сарын 18.

Усны бодлогын зөвлөл:

- 2017 оны 3 сард буюу Дэлхийн усны өдрийг “Хаягдал ус – Нөөц баялаг” уриан дор БОАЖЯ, JCI конгресс байгууллагатай хамтран хэлэлцүүлэг, “Усыг хэмнэлттэй хамгаалах, ашиглах – техник технологи” үзэсгэлэн, “Ус-хөгжлийн түлхүүр” оюутны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан.
- УИХ-ын гишүүн, Туул голын бохирдлыг бууруулах ажлын хэсгийн ахлагч А.Сүхбат, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Өргөдлийн байнгын хороотой хамтран “Ус ба хууль” зөвлөгөөн зохион байгуулсан.
- БОНХАЖ-ын сайдын А/301 тушаалаар шинэчлэн батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-д Усны зөвлөлийн гишүүдийн саналууд тусгагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөл:

- “Safety book 2016” ном гаргасан.
- Зөвлөлийн гишүүн сургалтын байгууллагууд ХАБЭА-н сургалт зөвлөгөөг давхардсан тоогоор 10000 гаруй хүнд үзүүлээ.

ОХУ-тай хамтран ажиллах зөвлөл

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), Оросын Холбооны Улсын Буриад Улсын худалдааны төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан “Буриадын Хөрөнгө Оруулалтын Боломжууд” сэдэвт бизнес-уулзалт болон Буриад улсын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр авч буй арга хэмжээний талаар семинар
- ОХУ-ын Шадар сайд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн Алс Дорнодын бүрэн эрхт төлөөлөгч Ю.П.Трутневийн айлчлахтай холбогдуулан Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Алс Дорнодын хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих агентлагтай хамтран зохион байгуулсан “Монгол-Оросын бизнес эрхлэгчдийн бизнес форум”
- МҮХАҮТ, ОХУ-ын Буриад улсын засгийн газар, Буриадын Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулсан “Монгол-Оросын бизнес эрхлэгчдийн чуулган”
- Шадар сайд Ө.Энхтүвшингийн санаачилгаар зохион байгуулсан “Монгол-Оросын хөрөнгө оруулалт, санхүүгийн салбар дахь хамтын ажиллагаа” чуулган
- ОХУ-ын Алтайн хязгаар, Эрхүү мужийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулсан Монгол-Оросын бизнес уулзалт
- ОХУ-ын Томск хотын худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулсан Монгол-Оросын бизнес уулзалт

Япон улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл

- ХХААХҮЯ-тай хамтран “Монгол-Японы Төр-Хувийн хэвшлийн хамтарсан 8 дугаар зөвлөлдөх уулзалт, үзэсгэлэн”-г Улаанбаатар хотноо зохион байгуулсан, 2017 оны 7 дугаар сар
- ГХЯ-тай хамтран Монгол-Хоккайдогийн 2 дах удаагийн бизнес уулзалт, 2017 оны 9 дүгээр сар
- Япон Улсын Парламентын бүлгийн төлөөлөгчид Монгол Улсад айлчлал хийж байгаатай холбогдуулан Монгол-Японы хүнсний чиглэлийн компаниудын бизнес уулзалт, 2017 оны 9 дүгээр сар
- “Фүүдэкс Жапан 2018 Үзэсгэлэн яармагын тухай” сэдэвт уулзалт, 2018 оны 5 дугаар сар
- “Монгол Коосэн Технологийн Коллежийн Оюутнуудыг Дадлагажигч Ажилтнаар Ажиллуулах Боломж” сэдэвт семинар, 2018 оны 6-р сар
- “Сав Баглаа Боодлын Технологи, Дизайн” сэдэвт уулзалт, 2018 оны 6-р сар
- МҮХАҮТ, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан “Монголын бүтээгдэхүүнийг Япон улсын зах зээлд экспортлоход дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт семинар, 2018 оны 6 дугаар сар
- МҮХАҮТ, ГХЯ, Японы “Хоккайдо-Монголын эдийн засгийн харилцааг дэмжих нийгэмлэг”-тэй хамтран зохион байгуулсан 3 дахь удаагийн “Монгол- Хоккайдогийн бизнес форум”, 2018 оны 9 дүгээр сар
- Япон Улсын Токио хотноо 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан 21 дэх удаагийн Олон улсын жижиг дунд бизнес эрхлэгчдийн “Tokyo International Industry Exhibition 2018” үзэсгэлэн

Хятад улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл:

- “БНХАУ-ын Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”, 2018 оны 9 дүгээр сарын 26
- Хөрөнгө оруулалтын орчны судалгаа.

Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл:

- МҮХАҮТ, БНХАУ-ын Бээжин хотод суугаа Бүгд Найрамдах Австри Улсын ЭСЯ-ны Худалдааны хэлтэс, Австрийн Эдийн засгийн танхимтай хамтран ээлжит “Монгол-Австрийн бизнес форум”-ыг 2018 оны 6-р сарын 9-ний өдөр зохион байгуулсан.
- “Прозит-2019 УБ Шинэ жилийн тоглолт”-ыг Монгол улсын ДБЭТ-ын тайзнаа 2018 оны 12-р сарын 17-ны өдөр МУДБЭТ-тай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Бээжин хотноо суух БНАУ-ын ЭСЯ-ны соёлын атташе Арнольд Обэрмайер хүрэлцэн ирж оролцлоо.



ӨМГӨӨЛӨЛ

Стратегийн зорилт 2. Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах

ӨМГӨӨЛӨЛ

2015-2018 онуудад Монголын эдийн засагт нүүрлэсэн хямралын улмаас бизнес эрхлэгчдэд ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарсан хүндхэн цаг үеийг тууллаа. Бизнес тулгарч буй бэрхшээл, асуудлыг тодорхойлох, шийдлийг олох, энэ чиглэлээр УИХ, ЗГ, яам агентлагуудад асуудал, санал зөвлөмжийг хүргүүлэх зэргээр ажилласан бөгөөд тодорхой зарим асуудлаар бизнесийн төлөөллүүдтэй хамтран судалгаа хийж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. Монгол Улсын Засгийн Газар солигдох бүрд шинээр томилогдсон гурван Ерөнхий сайд, тэдгээрийн кабинетын сайдуудтай Танхимын УЗ-ийн гишүүд, тэргүүлэгчид, бусад бизнесийн төлөөллийг оролцуулсан уулзалтуудыг зохион байгуулж, бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа асуудлыг бизнесийн орчныг сайжруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, бодлогын зөвлөмжийг багцлан танилцуулсан.

МҮХАҮТ-аас уламжлал болгон зохион байгуулдаг Business breakfast уулзалтанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх уригдан бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлуудын талаарх санал хүсэлтийг хүлээн авсан ба уг саналуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 56 заалт бүхий хариуг МҮХАҮТ-аар бизнес эрхлэгчдэд ирүүлсэн.




37
хуулийн
төсөл



25
бодлогын
баримт бичиг



35
хэлэлцүүлэг



23
мэдэгдэл

Энэ хугацаанд нийт бизнесийн холбогдолтой 37 хуулийн төсөлд санал өгч, 25 бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төслүүдийг боловсруулах ажилд оролцон ажилласан ба 35 хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулж 23 мэдэгдэл, уриалга гарган ажилласан байна. Өнгөрсөн хугацаанд бизнесийн хууль тогтоомжид санал өгч тусгуулах, бизнест тулгарч байгаа макро ба микро түвшний асуудлуудыг УИХ, Засгийн газар, холбогдох яам, агентлагуудад тавьж шийдвэрлүүлэх талаар санаачилгатай ажиллалаа.

Тухайлбал:

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг бизнес эрхлэгчдээр хэлэлцүүлэх, саналыг хуулийн төсөлд тусгуулах, хуулийг батлуулахад МҮХАҮТ-ын зүгээс идэвх санаачилгатай ажилласан. Мөн батлагдан гарсан хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг бизнес эрхлэгчдэд танилцуулах сургалтуудыг Сангийн яам, Татвар болон Гаалийн Ерөнхий газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий газартай хамтран зохион байгуулсан ба үүнд 350 орчим бизнес эрхлэгчдийг хамруулсан.

НӨАТ-ын тухай хууль

НӨАТ-ын тухай хуулийн өөрчлөлтөд эцсийн хэрэглэгч нь иргэн гэдэг ойлголт тусгагдаж, 2016 оны 1-р сарын 1-ээс хууль хэрэгжиж худалдан авалт хийсэн иргэн НӨАТ-ынхаа 2 хувийг буцааж авах эрх, сугалаанд орох боломж бүрдсэн. НӨАТ төлөгч нарт зориулсан сургалтуудыг Гааль, татварын Ерөнхий газар (ГТЕГ)-аас хамтран зохион байгуулсан.

УИХ-д тавьсан 8 зүйл бүхий шаардлага

Монгол Улсын Засгийн газраас ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нэрийн дор татвар нэмэх асуудлыг УИХ-ын чуулганаар оруулж байгааг МҮХАҮТ-аас эрс эсэргүүцэн, УИХ-д хандсан

8 шаардлага бүхий мэдэгдэлийг, Аж ахуйн нэгжид хандсан татвар төлөхгүй байх уриалгын хамт 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр гаргасан. Мэдэгдлийн дагуу УИХ-ын Дарга М.Энхболд Танхимын удирдлагууд, тэргүүлэгчдийн төлөөллийг 2017 оны 4 дүгээр сарын 13-нд хүлээн авч уулзан, нийт 8 асуудлыг хамтран хэрэгжүүлэхээр зөвшилцөж, УИХ-ын Дарга зөвлөмж гарган, ЗГХЭГ, Сангийн яам, Монгол банк болон Хөрөнгө оруулалтын газарт үүрэг хүргүүлэв. Энэ хүрээнд МҮХАУТ, Сангийн яамны татварын шинэчлэлийн ажилд идэвхтэй оролцож, Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд байр сууриа илэрхийлэн, саналаа хүргүүлж, УИХ-ын Байнгын хороотой нягт хамтран ажиллах эхлэл болсон. МҮХАУТ-аас зөвшилцсөн 8 асуудлыг дүгнэх зорилгоор 2017 оны 11 дүгээр сард УИХ-ын Дарга М.Энхболдтой уулзаж, Татварын багц хуулийг УИХ-аар яаралтай хэлэлцэх, валютын ханшийн өсөлт, зөрүүгээс болж хохирч, алдагдал хүлээж буй компаниудад зээл авсан өдрийн ханшаар төлбөрийг төлөх боломж олгох зэрэг шаардлагуудыг хэлж, 2018 оны Төсвийн тухай хууль, мөнгөний бодлогын талаар мөн цаашид анхааран ажиллах саналын хамт УИХ-ын Дарга М.Энхболдод хүргүүлсэн.



Хөдөлмөрийн хууль

МҮХАУТ нь 2016 оноос эхлэн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, олон удаа бизнес эрхлэгчдэд танилцуулах, санал авах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Бизнес эрхлэгчдээс ирүүлсэн зарчмын болон зүйл, заалтын саналуудыг нэгтгэж, ажлын хэсэгт нийт 80 гаруй саналыг хүргүүлж, 20 гаруй саналыг хуулийн төсөлд тусгуулж цаашлаад өөрчлөлт оруулах зарчмын саналуудыг УИХ, Засгийн газарт хүргүүлэн хоёр жил гаруй хугацаанд ажиллалаа. Одоогоор Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий НББСШУ-ны Байнгын хорооны дэд ажлын хэсэгт МҮХАУТ-ын төлөөлөл орж ажиллаж байна.

ЖДҮ-ийн тухай хууль

ХХААХҮЯ-нд байгуулагдсан “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах” ажлын хэсэгт Танхимын төлөөлөл өнгөрсөн 2 жилийн хугацаанд ажиллалаа. Хуулийн төсөлд бизнес эрхлэгчдийн саналыг тусгуулан ажиллахаас гадна бизнес эрхлэгчдээс санал авах, хэлэлцүүлэхээр олон удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Түүнчлэн УИХ-ын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо, ЖДҮ-ийн тухай хуулийг УИХ-ын чуулганд өргөн барих, хэлэлцүүлэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны дэд ажлын хэсэгт Танхимын төлөөлөл идэвхтэй ажиллаж байна.

Үүнээс онцолбол, ЭЗБХ-ны ажлын хэсгийг ахалсан УИХ-ын гишүүн Я.Содбаатар болон УИХ-ын эмэгтэй гишүүдтэй хамтран МҮХАУТ-д тус хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнд нь 11 мэргэжлийн холбоодтой дуу хоолойгоо нэгтгэж, зарчмын зөрүүтэй 7 санал, зүйл заалт бүрд өгөх саналыг нэгтгэн, УИХ-ын нийт гишүүдэд хүргүүлээд байна.

Хуулийн шинэчлэлээс гадна, Танхимаас ЖДҮХСангийн асуудалд онцгойлон ач холбогдол өгч, ХХААХҮЯ-наас зохион байгуулсан “ЖДҮ Хөгжүүлэх Сан: Асуудал ба Шийдэл” хэлэлцүүлэгт хүчтэй байр, сууриа илэрхийлж, саналаа хэлсэн. Үүний үр дүнд ХХААХҮЯ-ны ЖДҮХСангын төсөл сонгон шалгаруулах журмыг өөрчлөн, шинэчлэх ажлын хэсэгт орж ажиллах боллоо.

Татварын багц хууль

МҮХАУТ-аас татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхийг эсэргүүцэн, олон удаа хүчтэй байр сууриа илэрхийлж, манлайлан дуугарч, үүний үр дүнд Татварын багц хуулийг боловсруулахаас эхлэн УИХ-ын Чуулганд өргөн барих хүртэлх хугацаанд ажиллалаа.

МҮХАУТ-ын төлөөлөл Сангийн Сайдын 2017 оны 284 тоот тушаалаар байгуулагдсан “Монгол Улсын татварын орчинд дүн шинжилгээ хийж, татварын тэгш, шударга байдлыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, татварын орлогод үл нөлөөлөх, эсхүл орлого нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан, бизнес эрхлэгчдийн саналыг тусгаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Мөн Танхимаас “Монгол Улсын Татварын тогтолцооны шинэчлэл, татварын оновчлол судалгаа”-г гаргаж, УИХ-ын гишүүд, Засгийн газарт хүргүүлэн ажилласан. Түүнчлэн Засгийн газартай хамтран Татварын багц хуулийн төслийг бизнес эрхлэгчдэд танилцуулах, санал авах хэлэлцүүлгүүдийг удаа дараа зохион байгуулж, зарчмын 12, нарийвчилсан 55 саналыг ажлын хэсэгт хүргүүлж ажиллалаа. Мөн УИХ, Засгийн газарт ХХОАТ-ыг нэмэхгүй байх, ААНОАТ-ыг УИХ-ын чуулганаар дахин хэлэлцэх зэрэг мэдэгдэл гарган ажилласан. Өнөөдрийн байдлаар Татварын багц хуулийг УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Төсвийн Байнгын хорооны дэд ажлын хэсэгт Танхимын төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 2 сард тус Байнгын хороотой хамтран Татварын хуулийг танилцуулах хэлэлцүүлгийг хийж, 2019 оны 2 дугаар сарын 25-нд УИХ-ын Дарга, гишүүдэд хандсан “УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан, Татварын багц хуулийг хэлэлцүүлэх тухай” мэдэгдэлийг гаргалаа.

Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр :

Монгол улсаас Япон улстай байгуулах ЭЗТХ-ийн судалгааны үе шатнаас эхлүүлэн МҮХАУТ эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран ажилласан. 2015 онд тус судалгааны талаар бизнес эрхлэгчдэд мэдээлэл өгөх, саналыг тусгуулах хэд хэдэн уулзалтыг зохион байгуулж, Танхимын зүгээс Японы талтай хамтран ЭЗТХ-ийн гарал үүслийн гэрчилгээний журам, гэрчилгээний загварыг хамтран боловсруулж, баталсан.

2016 оны 6 дугаар сараас Монгол-Японы ЭЗТХ хэрэгжиж эхэлсэн бөгөөд МҮХАУТ-аас 2016 онд 318 ширхэг, 2017 онд 481 ширхэг, 2018 онд 800 ширхэг гарал үүслийн гэрчилгээг олгосон байна. Үүнд нийт 80 гаруй ААН-ийн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортоод байна.





Хэлэлцээрийг бизнес эрхлэгчдэд таниулах, хэрэгжилтийн явцад бизнес эрхлэгчдэд тулгарсан хүндрэл бэрхшээлийг шийдэх, хамрагдаагүй бүтээгдэхүүнүүдийг /чацарганы тос, эсгий шаахай, арьсан эдлэл/ нэмж хамруулах асуудалд Танхимаас онцгойлон анхаарч, ГХЯ-д тухай бүр саналыг хүргүүлэн, хамтарсан уулзалтууд зохион байгуулсан. Үр дүнд, Монгол-Японы ЭЗТХ-ийн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх шийдвэр гарсан.

Монгол-БНХАУ, Монгол-БНСУ хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээрүүд:

Гадаад харилцааны сайдын 2016 оны А/50 тоот тушаалаар байгуулагдсан "Монгол улс, БНСУ хооронд ЧХХ байгуулах боломж, нөхцлийг судлан, санал, дүгнэлт гаргах судалгаа"-ны ажлын хэсэгт МҮХАҮТ-аас бизнес эрхлэгчдийг төлөөлөн бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн дүрмийн хэсэгт ажиллав. Судалгааны үр дүнд, БНСУ-тай хэлэлцээр эхлүүлэх шийдвэр гарч, 2017 онд бизнес эрхлэгчдээс гаалийн татвараас хөнгөлүүлэх хүсэлтэй барааны санал авах, боломжийг судлах уулзалт, хэлэлцүүлгийг ГХЯ-тай хамтран зохион байгуулав.

Түүнчлэн, ГХЯ-нд "Монгол улс, БНХАУ хооронд ЧХХ байгуулах боломж, нөхцлийг судлан, санал, дүгнэлт гаргах судалгаа"-ны ажлын хэсэг 2018 онд байгуулагдаж, МҮХАҮТ-аас гарал үүслийн дүрэм, Аж үйлдвэр болон ЖДҮ-ийн чиглэлээр хамтран ажиллах боломжийг судлах хэсэгт ажиллаж байна.

Санал өгсөн хуулиуд, салбараар

Эдийн засаг, санхүү:

1. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хуулийн төсөл
2. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
3. Жижиг дунд үйлдвэрийн хуулийн төсөл
4. Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
5. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хууль
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
7. Татварын ерөнхий хууль
8. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
9. Татварын багц хуулийн төсөл
10. Банкны тухай хууль
11. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл

Бизнесийн эрх зүй:

1. Арбитрын тухай хуулийн төсөл
2. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөл

3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл
4. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн төсөл
5. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
6. Өмгөөллийн тухай хуулийн төсөл
7. Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
8. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах тухай хуулийн төсөл
9. Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журмын төсөл
10. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл
11. Оюуны өмчийн багц хуулийн төсөл

Худалдаа:

1. Худалдааны хуулийн төсөл
2. Гаалийн тухай хуулинд гарал үүслийн гэрчилгээний тухай заалт дахин оруулах тухай
3. Гаалийн татвар, тарифын тухай хууль
4. Гаалийн тухай хуульд шинэчилсэн өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
5. Демпингийн тухай

Хөдөлмөр, нийгмийн даатгал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн төсөл
2. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Стандарт, хэмжил зүй:

1. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай
2. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
3. Хэмжилзүйн тухай хууль

Бусад:

1. Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/
2. Органик хүнсний тухай хууль
3. Эрчим хүчний хэмнэлтийн хууль
4. Байгаль орчны багц хууль
5. Уул уурхайн багц хууль

Бодлогын баримт бичиг, салбараар

Эдийн засаг, санхүү:

1. Төрөөс баримтлах аж үйлдвэрийн бодлогын стратеги төлөвлөгөө
2. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр 2016-2020 хөтөлбөр
3. Монголын банкны холбооны дэргэдэх Ногоон зээлийн сан
4. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль
5. Нийслэлийн Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах журмын төсөл

Худалдаа:

1. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ 2020 дэд хөтөлбөр
2. Худалдаа хөрөнгө оруулалтын газрын зураг болон экспортын замын зургийн төлөвлөгөө
3. Монгол экспорт хөтөлбөр
4. ЭЗТХэлэлцээрийн гарал үүслийн журам
5. Монгол улсын үндэсний чанарын бодлого, чанарын хөтөлбөр
6. Импортын зарим барааны гаалийн татварыг нэмэгдүүлэх тухай санал

Хүнс, хөдөө аж ахуй:

1. Чацарганы шүүсний стандарт
2. "Монгол Чацаргана" газарзүйн заалт

Органик хүнс:

1. Органик хүнсний тухай хуулийг дагаж гарах журмуудын төсөл
2. Органик хүнсийг үйлдвэрлэхэд баримтлах журам
3. Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, түүнийг хэрэглэх журам
4. Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах журам
5. Газар тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам
6. Мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам
7. Хуулийг дагаж гарах хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам

Бусад:

1. Эрчим хүч хэмнэлтийн үндэсний хөтөлбөр
2. Эрчим хүч хэмнэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
3. Евро-5 шатахууны стандарт
4. Барилгын салбарт төрөөс баримтлах бодлогын төсөл
5. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэд арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмын төсөл



Business Breakfast уулзалт



Бизнес эрхлэгчдийг төртэй холбох, төр хувийн хэвшлийн хэлэлцлийг сайжруулах зорилгоор “Business breakfast” өглөөний уулзалтыг 2016 онд шинээр санаачлан хэрэгжүүлж эхэлсэн ба нийт 26 удаа зохион байгуулж 4000 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулсан байна.

Д/д	Оролцогч
2016	
1	УИХ-н гишүүн С.Бямбацогт
2	УИХ-н гишүүн Б.Гарамгайбаатар
3	Барилга хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ
4	Хууль зүйн сайд Д.Дорлигжав
5	Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат
6	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн
8	Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч асан Б.Жавхлан
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр
10	Монгол Улсын Ерөнхий сайд асан, эдийн засагч Р.Амаржаргал
11	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаяр
2017	
12	Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат
13	Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат
14	Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга П.Цагаан
15	УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар
16	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол
17	Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт
18	МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг
19	Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболд
20	Ерөнхийлөгчид нэр дэвшигч С.Ганбаатар
21	Ерөнхийлөгчид нэр дэвшигч Х.Баттулга
2018	
22	Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх
23	Байгаль орчин аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат
24	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд
25	Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан
26	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг

Бодлогын өмгөөллийн хэлэлцүүлэг, уулзалтууд

2015

1. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэг
3. Оюуны өмч ба зөрчил сэдэвт төр, хувийн хэвшлийн хэлэлцүүлэг
4. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль болон НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал
5. "Бизнес ба авлига" сэдвээр Улаанбаатар хотын барилгын салбарын бизнес эрхлэгчидтэй болон Орхон, Сүхбаатар, Дорнод, Өмнөговь зэрэг аймгийн ХАУТ-ын бизнес эрхлэгчдийг хамруулсан хэлэлцүүлэг
6. "Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016-2030 он)" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг

2016

1. Дэмпингийн тухай хуулийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн тухай хуулийн хэлэлцүүлэг
3. Импортын зарим барааны гаалийн татварыг нэмэгдүүлсэнтэй холбоотой компани аж ахуйн нэгжүүдтэй хийсэн хэлэлцүүлэг
4. МХЕГ болон МҮХАУТ хамтран зохион байгуулсан "Махны экспортын төрийн бодлого, түүний хэрэгжилт"-ийн тухай хэлэлцүүлэг
5. Цементийн импортын бизнес эрхлэгчдийн уулзалт хэлэлцүүлэг
6. "Худалдаа, тээврийг хөнгөвчлөхөд логистикийн гүйцэтгэх үүрэг" сэдэвт өдөрлөг, хэлэлцүүлэг
7. Барилгын салбарын хууль эрх зүйн орчны хэлэлцүүлэг
8. "Төрөөс экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт"-ийн тухай хэлэлцүүлэг
9. "Монголын банкнуудын холбоо, барилгын салбарын гарц, боломж" хэлэлцүүлэг уулзалт
10. Валютын ханш огцом өссөнтэй холбоотой гурван талын уулзалт хэлэлцүүлэг

2017

1. Эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмын төслийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг

3. Байгальд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тухай журмын хэлэлцүүлэг
4. УИХ-аар төсвийн тодотгол хэлэлцэхтэй холбоотойгоор хэлэлцүүлэг
5. "Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо" сэдвээр хэлэлцүүлэг
6. ЗГХЭГ-ын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлөөс "Хөрөнгө оруулагчдын төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай журам"-ын төслийн хэлэлцүүлэг
7. "Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг боловсруулах" журмын хэлэлцүүлэг
8. НЗДТГ-тай хамтран Утааны эсрэг хэлэлцүүлэг
9. Жижиг дунд үйлдвэрийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь хэлэлцүүлэг
10. Зөрчлийн тухай хуулийн хэлэлцүүлэг
11. Татварын багц хуулийн төсөл боловсруулахтай холбоотой Татварын орчны хэлэлцүүлэг
12. Үндэсний инновацийн шагналын журмын төсөл, Инновацийн төслийг бүртгэх, хэрэгжүүлэх журмын төсөл, Инновацийн төсөлд грант олгох журамд санал өгөх нээлттэй хэлэлцүүлэг

2018

1. Худалдаа хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн хэлэлцүүлэг
2. Татварын багц хуулийн 3 удаагийн хэлэлцүүлэг
3. Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх 3 удаагийн хэлэлцүүлэг
4. Төрийн худалдан авалт-Дотоодын үйлдвэрлэл хэлэлцүүлэг
5. Экспортонд тулгамдаж буй асуудлууд сэдэвт хэлэлцүүлэг
6. Хөдөлмөрийн хуулийн 2 удаагийн хэлэлцүүлэг

Мэдэгдэл уриалга

2015

1. Тавантолгойг ажиллуулах тухай УИХ, ЗГ-т хандсан МҮХАУТ-ын уриалга
2. "Бизнес эрхлэгчдэд боломж олгож байж эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс гарна" мэдэгдэл
3. "Бидэнд дэлхийн дэвжээ ойрхон байна"
4. "Баялаг бүтээгчдээ нэг гараанаас гаргацгаая"
5. Бизнес эрхлэгчдийн анхааралд: Эдийн засгийн эрх чөлөөгөө хангацгаая!





6. "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах, хугацааг сунгах" мэдэгдэл
7. "Ил тод болгох хөрөнгөө бүртгүүлж батлуулахад саадгүй боллоо"
8. "Бараа, ажил, үйлчилгээ борлуулагч хувь хүн, хуулийн этгээдүүдэд хүргэх уриалга"
9. "Улс орны эдийн засаг тогтвортой байдлыг нэхэж байна" мэдэгдэл

2016

1. "Улс орны эдийн засаг тогтвортой байдлыг нэхэж байна" мэдэгдэл
2. Компаний засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөртэй холбоотой мэдэгдэл
3. Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, МҮХАҮТ-ын Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл хамтран "Хүртээмжтэй санхүүжилтын санаачилгыг хэрэгжүүлцгээе" тунхаг бичиг
4. "Бизнес эрхлэгчдэд чиглэсэн оновчтой бодлогыг дэмжинэ" уриалга
5. "Төр хувийн хэвшлийн түншлэл, хэлэлцэлийг хөгжүүлэн шинэ шатанд гарган ажиллахыг УИХ, Засгийн газарт УРИАЛЖ байна" уриалга
6. Татварын хувь хэмжээг нэмэх нь зөв шийдэл биш

7. Валютын ханшийн өсөлттэй холбогдуулан арилжааны банкуудад гаргасан уриалга

2017

1. Монгол Улсын Засгийн газраас ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан МҮХАҮТ-аас УИХ-ын дарга, гишүүдэд хандсан мэдэгдэл
2. МҮХАҮТ-аас Монгол Улсын Засгийн газарт талархал илэрхийлж, ажлаа эрчимжүүлэхийг уриалсан уриалга

2018

1. Төрийн хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, Нийтийн санхүүгийн ил тод байдлыг хангах тухай
2. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх 7 хоногийн аян
3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Чуулганаар дахин хэлэлцэх тухай
4. Төр, Засгаас авлига болон аливаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажлаа бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтөнд сөрөг үр дагаваргүй хийхэд онцгой анхаарах, Улсын Их Хурал дээр гацаад байгаа бизнестэй холбоотой хуулиудыг хэлэлцэн батлахыг шаардсан мэдэгдэл
5. Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан, Татварын багц хуулийн төслийг хэлэлцүүлэх тухай мэдэгдэл

ДЭМЖИХ


Стратегийн зорилт 3. Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараанэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах

ДЭМЖИХ

Бизнесийг дэмжих хүрээнд гишүүдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад анхаарч тэдгээрт шаардлагатай төрөл бүрийн арга хэмжээ, үзэсгэлэнг зохион байгуулан ажилласан. Гишүүдийн дунд сэтгэл ханамжийн судалгааг жил бүр явуулж, судалгааны үр дүнд шинжилгээ хийж, үйлчилгээ арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулах мөн гишүүдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход онцгойлон анхаарсан. Мөн гишүүдэд зориулсан B2B арга хэмжээг санаачлан тогтмол амжилттай зохион байгуулсан. Орон нутгийн бизнес эрхлэгчдэд зориулсан Chamber bus, Entrepreneurship challenge хөтөлбөрүүдийг шинээр санаачлан хэрэгжүүлээ.

ГИШҮҮНЧЛЭЛ

МҮХАҮТ нь нийт 3395 гишүүнтэй. Үүнээс орон нутгийн гишүүд 2115, Улаанбаатар хотын гишүүдийн тоо 1280 болж өссөн нь сүүлийн 4 жилийн хугацаанд Улаанбаатар хотын гишүүдийн тоо анх удаагаа 4 оронтой буюу 1000 давсан байна.



МҮХАҮТ-аас 2014-2018 оны хооронд нийт 255 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 41717 бизнес эрхлэгчдийг хамруулсан байна.

B2B уулзалт



Бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, цаг үеийн асуудлаар мэдээлэл хуваалцах, санал солилцох чөлөөт индэрийг бий болгох зорилгоор B2B уулзалтуудыг тодорхой сэдвүүдийн хүрээнд 2015 оноос зохион байгуулж эхлэсэн ба нийт 29 удаагийн арга хэмжээнд 2600 гаруй бизнес эрхлэгчид оролцсон.

Д/д	Сэдэв
2015	
1	Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр
2	Young entrepreneurs
3	Худалдаа хөнгөвчлөх асуудлууд
4	Бизнесийн салбар зөвлөлүүдийн уялдаа холбоо
5	Бизнес эрхлэгч Та эрсдэлд бэлэн үү?
2016	
1	Хөдөлмөрийн харилцаан дахь эрх зүйн орчин
2	Тогтвортой хөгжил ба тогтвортой санхүүжилт
3	Corporate & start-up
4	Нягтлан бодох бүртгэл болон аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, өөрчлөлт болон тоон гарын үсгийн хэрэглээ, хэрэгжүүлэлт
5	Гаалийн зуучлагч байгууллагын өнөөгийн байдал анхаарах асуудлууд
6	Макро эдийн засгийн төлөв байдал: Боломж уу?
7	Худалдааны хууль, хөдөлмөрийн хууль, арбитрын хуулийн танилцуулга
8	Монгол-Солонгосын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа
2017	
1	Үйлдвэрлэлийн дадлага сургалтын чиглэлээр
2	Инноваци
3	Техник технологийн дэвшил
4	Санал, санаачилга, шийдэл
5	Экспортыг дэмжих төсөл
6	Хөрөнгө оруулалтыг татах боломж





7	Эрчим хүчний хэмнэлт
8	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд - Шарк Танк
2018	
1	Үзэсгэлэн худалдаанд бараа бүтээгдэхүүнээ хэрхэн танилцуулах вэ
2	Барилгын материал ханган нийлүүлэгчдийн уулзалт
3	Худалдаа
4	Бизнесийн эрх зүй
5	Европын холбооны МУ-ын худалдааг дэмжих төсөл
6	Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хэмнэлтийг нэвтрүүлэх
7	Мэргэжлийн боловсрол
8	Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ 2020 нийслэлийн дэд хөтөлбөр

Олон улсын хэмжээний томоохон арга хэмжээнүүд:

Ази Европын дээд хэмжээний уулзалт

2016 оны 7 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд Ази Европын дээд хэмжээний уулзалт /АСЕМ/-ын үеэр Ази Европын бизнес форумын “Ази Европын уялдаа холбоо” салбар хуралдааныг зохион байгуулсан. Уг хуралдаанд танхимаас нийт 117 бизнес эрхлэгчид салбар танхимын төлөөллийг хамруулсан. 7 дугаар сарын 14-ний өдөр Ази Европын дээд хэмжээний уулзалтанд оролцсон Камбоджийн Худалдааны Танхим, Торгоны зам Олон улсын худалдааны танхим, Тайландын Худалдааны Танхим болон Тайланд улсын худалдааны зөвлөлийнхнөөс бүрдсэн 15 төлөөлөгчдийг МҮХАҮТ-ын удирдлагууд хүлээн авч уулзсан.

Монгол, Орос, Хятадын худалдаа, эдийн засгийн 13-р дээд хэмжээний уулзалт



2017 онд Монгол, орос, хятадын худалдаа, эдийн засгийн 13 дугаар дээд хэмжээний уулзалт, нэгдсэн хэлэлцүүлэгт гурван улсын бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчдийн 350 гаруй төлөөлөл цуглан, бүс нутгийн онцлог, нөөц боломжтой танилцаж, гурван улсын хил худалдаа, хамтын ажиллагааны хэрэгцээ, боломжуудыг хэлэлцсэн.

Монгол-Оросын санаачлага-2018



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нарын 2017 онд хүрсэн тохиролцоо ажил хэрэг болж, “Монгол-Оросын санаачилга-2018” цуврал арга хэмжээ 2018 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотод боллоо. Энэ үеэр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

- “Монгол-Орос: Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа стратегийн түншлэлийг хөгжүүлэх тулхүүр хүчин зүйл болох нь” эдийн засгийн чуулга уулзалт
- Оросын дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн болон Оросын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа
- И.Моисеевын нэрэмжит академик чуулгын тоглолт

Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ-уудын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвилигийн айлчлал



Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ-ын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвили Монгол улсад 2018 оны 9 дүгээр сарын 5-10-ны хооронд айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд “Ази Номхон Далайн Бүс Нутгийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Холбоогоор дамжуулан бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь” чуулга уулзалт, Ази Номхон далайн бүс нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан бөгөөд уг чуулга уулзалтуудад гадны 7 орны 32 төлөөлөгч, дотоодын 500 орчим бизнес эрхлэгчид оролцсон.

Мөн Ерөнхийлөгч Джамал Инайшвили МУ-ын ерөнхийлөгч Х.Баттулга, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нартай уулзалт хийв.

Орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан арга хэмжээ:

“Chamber bus” хөтөлбөр



Салбар танхимын гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, Улаанбаатар хотын томоохон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, мөн тухайн аймаг орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй уулзалт хийж санал бодлоо солилцох, төрийн ордонтой танилцах зорилгоор МҮХАҮТ-аас “Chamber bus” хөтөлбөрийг 2017 онд санаачилан амжилттай хэрэгжүүлсэн. 2017 онд “Автобустай аялал”-аар 13 аймгийн 499 бизнес эрхлэгч, 2018 онд 9 аймаг, нийслэлийн 4 дүүргийн 540 бизнес эрхлэгч нар хамрагдсан байна. “Автобустай аялал”-ын хүрээнд ТЭСО ХХК, Өүлэн менч ХХК, Тод оймс ХХК, Талх чихэр ХК, Траст трейд ХХК, Их эргэлт ХХК, Чингэлтэй дүүргийн бизнес инкубатор төв, Түмэн шувуут ХХК гэх мэт байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.



2018 оны 5 дугаар сарын 9-нд ОХУ-ын Улаан-Үд хотод Монгол-Буриадын бизнес эрхлэгчдийн форумыг зохион байгуулж, Монгол улсаас УИХ-ын гишүүн Н.Оюундарь, МҮХАҮТ-аас Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Оюунтэгшээр ахлуулсан 130 гаруй бизнес эрхлэгчид оролцож ОХУ-ын бизнес эрхлэгчтэй уулзаж, хамтран ажиллах, ялалтын баярт оролцох, үйлдвэрүүдтэй танилцах аялал хийсэн.

“Entrepreneurship Challenge” хөтөлбөр

Орон нутгийн гарааны бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хөдөлмөр эрхлэх боломж олгох, бизнесээ амжилттай эхлүүлэх орлогын эх үүсвэртэй болгох, үйл ажиллагааг нь дэмжих, бэхжүүлэх, шинээр санаагаа загварчлах болон хуучин бизнесээ шинэ загварт шилжүүлэх, Entrepreneur санаачилгыг өрнүүлэх, Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 2016 оноос “Entrepreneurship Challenge” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд нэг аймагт 8 арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Үүнд:

1. Business breakfast арга хэмжээ
2. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт
3. Жижиг дунд үйлдвэрлэгчдэд зориулсан сургалт
4. Баг бүрэлдэхүүн аймгийн бизнес эрхлэгчдэд ажлын байран дээр нь очиж зөвлөгөө өгөх
 - Бизнесээ эхлээд удаагүй байгаа 5 ААН, үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр олон жил явж байгаа ч төдийлөн амжилтанд хүрэхгүй байгаа 5 ААН, тодорхой хэмжээгээр сайн явж байгаа ч зөвлөгөө авах шаардлагатай байгаа 5 ААН-үүдийг олж, зөвлөгөө өгөх
5. Нэрийн хуудас солилцох уулзалт
 - Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх
6. ТВ шууд нэвтрүүлэгт оролцож Бизнесийн орчны талаар мэдээлэл өгөх
7. Төр хувийн хэвшлийн уулзалт
8. Entrepreneur залуучуудын уулзалт

Хөтөлбөрт 2016 онд зүүн 3 аймгийн 670 оролцогч, 2017 онд Баян-Өлгий, Увс, Ховд гэх мэт нийт 8 аймгийн 1500 гаруй оролцогч, 2018 онд Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Дархан-Уул, Дундговь аймгуудад зохион байгуулагдаж 800 оролцогчид хамрагдсан.



Шагнал, шалгаруулалт

ТОП-100 аж ахуй нэгж



Монгол улсын нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй ТОП-100 аж ахуйн нэгжийг Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТ хамтран жил бүр өргөмжилдөг уламжлалтай бөгөөд 2015 оноос Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн 4 дэх жилдээ эрэмбэллээ.

“Торгоны зам” шагнал гардуулах арга хэмжээ

2007 оноос нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй Олон улсын байгууллагууд, хоёр талын техникийн туслалцааны болон бусад гадаадын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүд, Дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон гадны иргэдийг онцлон шалгаруулах, урамшуулан дэмжих, тэднийг нийтэд таниулах зорилгоор “Торгоны зам” шагнал гардуулах арга хэмжээг 2 жил тутамд зохион байгуулдаг уламжлалтай бөгөөд “Торгоны зам 2016”, “Торгоны зам 2018” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



Үндэсний чанарын чуулган



Дэлхийн Чанарын 7 хоногийг тохиолдуулан Европын холбооны “Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр Стандартчилал хэмжил зүйн газартай хамтран Үндэсний чанарын чуулганыг 2015 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж байна. Энэхүү чуулганы үеэр Чанарын тогтолцооны талаар форум, Монгол улсын үндэсний чанарын бодлого ба хөтөлбөр хэлэлцүүлэг, итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллага, лабораториудын үзэсгэлэн, Үндэсний чанарын шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулдаг.



“Entrepreneur” шагнал гардуулах ёслолын арга хэмжээ



МҮХАҮТ-аас жил бүр уламжлал болгон тухайн оны онцлох 10 аж ахуй нэгж салбарын шилдгүүдийг тодруулдаг “Entrepreneur” шагнал гардуулах ёслолын арга хэмжээг тогтмол амжилттай зохион байгуулсан ба 2016 онд тус арга хэмжээний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.

Бусад арга хэмжээнүүд:

МҮХАҮТ-аас зохион байгуулсан арга хэмжээ

1. Лэйди энтрепренёр 2015, 2017
2. Бизнес лиг 2015, 2016, 2017, 2018
3. Худалдааг хөнгөвчлөх үндэсний семинар
4. “Тээвэр хөнгөвчлөх арга хэрэгслүүд” үндэсний семинар
5. “БНХАУ-ын зах зээлд нэвтрэх боломж” сэдэвт сургалт семинар
6. “Чөлөөт бүсийн хууль эрхзүйн орчин” уулзалт

7. "Хаягдал ус - нөөц баялаг" форум
8. "Ногоон технологи" зөвлөгөөн
9. "Идэхийн тулд амьдрах уу?, Амьдрахын тулд идэх үү?" хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, эрдэмтдийн чуулга уулзалт
10. "Эрүүл хүнс - бидний сонголт" уулзалт
11. Хуулийн яармаг өдөрлөг

Төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан арга хэмжээ

1. АҮЯ-тай хамтарсан "Японы зах зээлд хэн гарах вэ" уулзалт
2. АҮЯ-тай хамтарсан "Алтанбулаг-2015" эдийн засгийн чуулга уулзалт
3. АҮЯ-тай хамтарсан "Санхүүгийн түрээсийн үйлчилгээ-2015" арга хэмжээ
4. АҮЯ-тай хамтарсан "Монголын энтрепренёруудын нэгдсэн чуулган 2015"
5. АҮЯ-ны сайд Д.Эрдэнэбат, Буриядын танхимын дарга И.Зураев болон Бурятмяспром ХХК-ны удирдлагуудтай хийсэн уулзалт
6. АҮЯ-тай хамтарсан Евразийн комиссын гишүүдтэй 25 байгууллагын 40 гаруй бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт
7. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, АҮЯ-тай хамтарсан ЖДҮ эрхлэгчдийн үндэсний чуулган
8. СЗХ, ЖАЙКА-тай хамтарсан "IPO-dual listing" семинар
9. ГТЕГ-тай хамтарсан НӨАТ-ын цахим падаан үүсгэх, НӨАТ-ын цахим тайлан гаргах болон анхаарах асуудлууд сэдэвт сургалт
10. ОБЕГ-тай хамтарсан гамшгийн эрсдэлийг бууруулахад төр-хувийн хэвшлийн түншлэл форум
11. СЗХ-той хамтарсан үнэт цаасны зах зээлийн чадавхыг бэхжүүлэх хэлэлцүүлэг, уулзалт
12. ХХААХҮЯ, НХААГ-тай хамтарсан "Монгол, Японы хөдөө аж ахуйн салбарын анхдугаар форум"
13. ХХААХҮЯ-тай хамтарсан Органик хүнс, хөдөө аж ахуйн чуулган, 2016-2018
14. БХБЯ, НЗДТГ, МБУА, МБМУХ, Барилга.Мн-тэй хамтарсан "Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган"
15. ЭХЯ, ЭХЗХ-той хамтарсан "Сэргээгдэх эрчим хүчний форум"
16. БОАЖЯ-тай хамтарсан "Бага нүүрстөрөгч бүхий төслүүдийг дэмжих Хамтарсан кредит олгох механизм" сэдэвт семинар
17. Монгол экспорт хөтөлбөрийн төслийг танилцуулах уулзалт

Олон улсын ба төрийн бус байгууллагууд, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулсан арга хэмжээ

1. ИТС буюу Олон улсын худалдааны төвийн гүйцэтгэх захирал Аранча Гонзалес бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй хийсэн уулзалт
2. ЕХ-ны худалдааны өдөрлөг
3. ОУВС-тай хамтарсан "ЖДҮ эрхлэгчдэд татварын хууль тогтоомжийг даган мөрдөхөд учирч буй хүндрэл бэрхшээл" сэдэвт хэлэлцүүлэг
4. НҮБ-ын ХХААБ, ХХААХҮЯ-тай хамтарсан "Махны экспортын форум"
5. НҮБ-ын Даян дэлхийн гэрээний шилжилт хөдөлгөөний асуудлаарх үндэсний зөвлөлдөх уулзалт
6. Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Юнитерра хөтөлбөртэй хамтарсан Монгол улсын ноос ноолуурын салбарын бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт
7. МУЗН-тай хамтарсан Ази, номхон далайн бүсийн худалдан авах ажиллагааны талаар уулзалт
8. Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтарсан "Хуульчид зөвлөж байна" нээлттэй өдөрлөг
9. Отгонтэнгэр Их Сургууль, ШХА-ын Ногоон Алт төслийн маркетингийн бүрэлдэхүүн хэсэг, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтарсан "Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг ОУ-ын зах зээлд гаргах боломж, арга зам" сэдэвт эрдэм шинжилгээний хурал
10. Startup Mongolia ТББ-тай хамтарсан гарааны бизнесийг дэмжих "Boosting Mongolia" уулзалт
11. Нефть хийн үндэсний ассоциаци төрийн бус байгууллагатай хамтарсан евро стандартыг батлуулах ажлын хэсгийн уулзалт
12. Нефть хийн үндэсний ассоциаци, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч нарын хамтарсан хурал
13. Аялал жуулчлалын холбоотой хамтарсан Аялал жуулчлалын чуулган, "Тогтвортой аялал жуулчлал" семинар
14. "Интернет маркетинг" конференц
15. Монголын маркетингийн холбоотой хамтран "Маркетингийн зөвлөгөө өгөх нээлттэй өдөрлөг"
16. Их Британийг гадаадад сурталчлах "GREAT" төслийн танилцуулга уулзалт
17. АНУ-ын махны холбооны дэд ерөнхийлөгч болон Монголын махны компаниудын уулзалт
18. Худалдаа, тээврийн салбарын хамтарсан уулзалт
19. Оюу-толгой ХХК-ийн ханган нийлүүлэгчдийн уулзалт
20. БНСУ-ын Имарт сүлжээ дэлгүүрийн худалдан авалтын багийнхантай хамтарсан "Export to Korea" бизнес уулзалт



ҮЗЭСГЭЛЭН


Гадаад үзэсгэлэн

Монголын экспортын бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад дэмжих, сурталчлах зорилгоор БНХАУ, ОХУ, Вьетнам, Япон, БНСУ, БНАСУ, Малайз, БНЭУ, ХБНГУ зэрэг 9 улсын 60 гаруй олон улсын үзэсгэлэнд оролцсон.

Монгол-Хятадын экспо



Монгол-Хятадын экспог ӨМӨЗО-ны Хөх хотод 2015, 2017 онуудад тус тус зохион байгуулсан ба үзэсгэлэнд давхардсан тоогоор нийт 613 компанийн 1134 бизнес эрхлэгчдийг хамруулж 13.1 сая орчим юанийн борлуулалт хийсэн.



Базаар берлин Экспо

ХБНГУ-ын Берлин хотноо зохион байгуулагддаг Базаар берлин үзэсгэлэнд 2015-2018 онуудад нийт 40 гаруй аж ахуй нэгжийн хамтаар амжилттай оролцсон.

Зохион байгуулсан үзэсгэлэнгүүд:

БНХАУ

1. Бээжин хот, "Торгоны замын ач холбогдол" сэдэвт хөрөнгө оруулалтын нэгдсэн форум, үзэсгэлэн
2. ӨМӨЗО-ны Хөх хот, "Азийн цагаан сар" ОУ-ын үзэсгэлэн худалдаа, 2016
3. ӨМӨЗО-ны "Бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа", 2017
4. ӨМӨЗО-ны Бугат хот, Танхимуудын уулзалт, үзэсгэлэн, 2016
5. Эрээн хот, "Монголын бараа бүтээгдэхүүн"-ий үзэсгэлэн, 2018
6. Эрээн хот, "Хятад-Монгол-Орос улсын эдийн засаг, худалдаа хамтын ажиллагааны чуулга уулзалт, үзэсгэлэн", 2015-2018
7. Эрээн хот, "ОУ-ын бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн", 2018
8. Эрээн хотын үзэсгэлэн, 2015-2018
9. Эрээн хот, "Олон улсын үндэстэн ястны онцлог бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн", 2016-2018
10. Шиньжан Уйгарын ӨЗО, "Олон улсын үзэсгэлэн", 2015, 2016
11. Шиньжан Уйгарын ӨЗО, "Хятад-Ази-Европ" эскпо, 2016
12. Жилин мужийн Чаньчунь хот, "Зүүн хойд азийн худалдаа хөрөнгө оруулалт" чуулга уулзалт, үзэсгэлэн", 2015, 2016
13. Шаньси мужийн Сиань хот, "Шанхайн хамтын ажиллагааны орнуудын форум, үзэсгэлэн", 2016
14. Харбин хот, "Harbin Asian Cold Zone EXPO" ОУ-ын үзэсгэлэн, 2016
15. Ий-Үү хот, "Шилдэг импорт, экспортын барааны үзэсгэлэн", 2017, 2018
16. Тунляо хот, Үндэстэн ястны бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, 2016
17. Тяньжин хот, "Олон улсын импортын бараа бүтээгдэхүүний эскпо", 2017, 2018
18. Гуанжоу хот, "Canton Fair", 2015-2018
19. Гуанжоу хот, "Сав баглаа боодлын үзэсгэлэн", 2018
20. Манжуур хот, "Олон улсын шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн", 2017, 2018
21. Хайлаар хот, "Хятад-Орос-Монгол 3-н орны эдийн засаг, худалдааны хэлэлцээрийн үзэсгэлэн", 2015-2018
22. Шаньдун мужийн Лин-И хот, "Олон улсын худалдаа, логистикийн экспо", 2018



Бусад:

1. ОХУ-ын Эрхүү хот, “Шинэ жилийн үзэсгэлэн”, 2015
2. ОХУ-ын Эрхүү хот, “Агро үйлдвэрийн үзэсгэлэн”, 2015
3. БНАСУ-ын Хаврын яармаг, 2015
4. Вьетнам улсын Хо Ши Мин хот, “FOOD-EXPO VIETNAM” үзэсгэлэн, 2015
5. Вьетнам экспо, 2015, 2016
6. БНСУ-ын Геонгсаннам мужийн Жинжү хот, “Хүнс, ХАА-н бүтээгдэхүүний үзэсгэлэн”, 2015, 2016
7. БНСУ-ын Дунхэ хот, “2017 GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн”, 2017
8. БНЭУ-ын Хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн, 2017
9. БНСУ-ын Сөүл хот, “Supremium” үзэсгэлэн, 2018
10. БНСУ-ын Сөүл хот, “Korea food week” үзэсгэлэн, 2018
11. Малайз улсын Куала Лумпур хот, “Олон улсын халал бүтээгдэхүүний үзэсгэлэн”, 2016
12. Малайз улс, “MINAS” халал бүтээгдэхүүний үзэсгэлэн, 2016

Дотоод үзэсгэлэн

Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх зорилгоор давхардсан тоогоор 40 орчим үзэсгэлэнг төрийн болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи



МҮХАҮТ-аас жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортыг дэмжих, дэвшилтэт технологийг танилцуулах зорилгоор зохион байгуулдаг “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи” үзэсгэлэнг тогтмол амжилттай зохион байгуулав. Тус үзэсгэлэнд давхардсан тоогоор дотоодын нийт 337 компани, БНАСУ, ОХУ, Бүгд Найрамдах Чех улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Бүгд Найрамдах Польш улс, Пакистан, Тайвань, Хонг Конг, Малайз, БНСУ, Унгар зэрэг орнуудын 67 компаниуд оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи сурталчилсан

байна.

Улаанбаатар түншлэл



МҮХАҮТ, НЗДТГ-тай жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Улаанбаатар түншлэл” олон улсын намрын үзэсгэлэн яармагийг тогтмол амжилттай зохион байгуулсан ба 2015 онд Монгол улсад үзэсгэлэнгийн салбар үүсч хөгжсөний 40 жилийн ойг үзэсгэлэнгийн үеэр тэмдэглэн өнгөрүүлсэн. Тус үзэсгэлэнд давхардсан тоогоор 360 гаруй дотоодын аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчид болон ОХУ, Чех, Непал, Хонг Конг, Тайвань зэрэг орнуудаас 60 гаруй компаниуд оролцсон байна.

Алтанбулаг экспо



2016 оны 5 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд “Алтанбулаг экспо 2016” арга хэмжээг Аж үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яам, МҮХАҮТ-ын Сэлэнгэ аймаг дахь салбар танхимтай хамтран амжилттай зохион байгуулсан. Алтанбулаг экспо 2016” олон улсын форум, үзэсгэлэнг зохион байгуулснаар 2016 оны 05 дугаар сарын 21-22-ы өдрүүдэд Алтанбулагийн чөлөөт бүс рүү 2850 тээврийн хэрэгсэл, 9229 зорчигч нэвтэрч, БНХАУ-ын талаас 30 гаруй, ОХУ-ын талаас 20 гаруй, манай талаас 50 орчим бизнес эрхлэгч, мөн тооны хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачид оролцсон. Тус үзэсгэлэнд дотоодын 120 гаруй аж ахуй нэгж оролцож, бараа, бүтээгдэхүүнээ танилцуулсан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр 112.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн.






Бусад үзэсгэлэнгүүд

- Монгол-Оросын санаачилга-2018 үзэсгэлэн
- Үндэсний чанарын үзэсгэлэн, 2016, 2017
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ-2015 үзэсгэлэн
- Ногоон технологи” үзэсгэлэн, 2015-2018
- Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо технологийн үзэсгэлэн, 2017
- Монголд үйлдвэрлэв үзэсгэлэн, 2016, 2017
- Цагаан сар-2018 үзэсгэлэн
- Алтанбулаг Экспо-2016
- “Их хотын хямдрал” фестиваль, 2018
- Монголын боловсрол-2015 үзэсгэлэн
- ЖДҮ-ийн үндэсний зөвлөгөөнд зориулсан үзэсгэлэн
- Coal Mongolia-2015 үзэсгэлэн
- Coal and Metals Mongolia-2016 үзэсгэлэн
- Монголия Майнинг 2016 олон улсын уул уурхай, газрын тосны үзэсгэлэн
- Ворота в Азию ОХУ-ын бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн, 2015-2018
- Бугатын өдрүүд ӨМӨЗО-ны бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, 2016
- ӨМӨЗО-ны ССРIT-тай хамтран зохион байгуулсан Хөх хотын аж ахуй нэгжүүдийн үзэсгэлэн
- Хятад машин механизм, электроникийн брэнд бүтээгдэхүүн-2017 үзэсгэлэн
- Хятадын СМЕК байгууллагаас зохион байгуулсан “Гэр ахуйн материал” үзэсгэлэн
- License Academy - Японы Их Сургуулийн Сонины Газар Японы Боловсрол, ЖЕТРО төлөөлөгчийн газрын сурталчилгааны үзэсгэлэн


ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль, МҮХАУТ-ын танхимын дүрэмд заасны дагуу гадаад худалдааны баримт бичиг олгох, бизнесийн маргааныг хянан шийдвэрлэх, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ ба ногоон шошго олгох үйлчилгээнүүдийг үзүүлдэг.


Гарал үүслийн гэрчилгээний олголт
Нийт: 49369



Органик бүтээгдэхүүний гэрчилгээ




Экспертизийн үйлчилгээ
Нийт: 1235



Бизнесийн хэрэг, маргааныг шийдвэрлэх үйлчилгээ

2015-2018 оны хооронд шинээр 301 хэрэг хүлээн авсан бөгөөд 235 хэргийг хянан шийдвэрлэсэн.



Гадаад худалдааны баримт бичгүүд



Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ



Танхимын дэргэд Европын сэргээн босголтын хөгжлийн банкны санхүүжүүлтээр “БМЭЗ” төв буюу Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулсан ба 2015-2018 оны хооронд нийт 81 хүсэлт хүлээж авсан ба 21 хэргийг шийдвэрлэсэн.

ХОЛБОХ

Стратегийн зорилт 4. Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх

ХОЛБОХ

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн ба төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, аймаг дүүргүүдийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төрөл бүрийн арга хэмжээ хамтран зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах зорилгоор 2014-2018 оны хооронд давхардсан тоогоор нийт 38 санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажилласан.

2015

Чингэлтэй дүүрэг
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Олон нийтийн байгууллагууд
Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийн төв
Монгол улсын Шинжлэх ухааны академи
МУИС, Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Зээлийн батлан даалтын сан
Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
МУИС Бизнесийн сургууль
Хөдөлмөрийн яам, Нийгмийн түншлэгчид
"Шингэрүүлсэн хийн аж ахуй эрхлэгчдийн" ТББ
Санхүү эдийн засгийн дээд сургууль

2016

Монголын хуульчдын холбоо
Скай Хайпермаркет ХХК
Онцгой байдлын ерөнхий газар
Монголын хөрөнгийн бирж
Нефть хийн үндэсний ассоциаци
ХХААХҮЯ, Номин тав трейд ХХК
Монгол улсын эрчим хүчний зохицуулах хороо

2017

Монгол улсын Их Хурлын Тамгын газар
Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яам
Сонгино хайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Үндэсний хөгжлийн газар
Увс аймгийн засаг даргын тамгын газар
Чингэлтэй дүүрэг /шинэчилсэн/
Налайх дүүрэг
Төв аймгийн засаг даргын тамгын газар
Багахангай дүүрэг
Замын-Үүд Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба
Аялал жуулчлалын холбоо
Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газар
Баянгол дүүргийн засаг даргын тамгын газар

2018

Багануур дүүрэг
Скай Хайпермаркет ХХК /шинэчилсэн/
Монголын хуульчдын холбоо /шинэчилсэн/
Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль
Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
Сайнбиотех ХХК, Чийз републик ХХК, Нүүдэл Жи ХХК, НВЦ ХХК



Гадаад хамтын ажиллагаа

МҮХАУТ нь дэлхийн 100 гаруй орны 126 худалдааг дэмжих байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ 7 оронд өөрийн төлөөлөгчөө томилон ажиллуулж байна.



МҮХАУТ-ын дарга М.Оюунчимэг Ази Номхон Далайн Орнуудын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбоо /CACCI/-ны 2016 оны 11 дүгээр сард Тайвань улсад болсон 30 дахь удаагийн уулзалт дээр Дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон нь МҮХАУТ-аас анх удаагаа CACCI-ны өндөр албан тушаалд сонгогдсон, мөн CACCI-ны Дэд ерөнхийлөгчөөр анх удаа эмэгтэй хүн сонгогдсон бахархуштай үйл явдал болсон ба Туркийн Стамбул хотноо зохион байгуулагдсан 32 дахь удаагийн уулзалтан дээр улиран сонгогдов.

Мөн 2016 онд Дэлхийн танхимуудын холбоо /WCF/-ны Ерөнхий зөвлөлийн гишүүнээр, 2015 оноос Торгоны замын олон улсын худалдааны танхим (SRCIC)-ын Дэд ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж байна.



НҮБ-ийн Даян дэлхийн гэрээ (UN Global Compact)

НҮБ-ийн Даян дэлхийн гэрээний Монгол улс дахь сүлжээ байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийг НҮБ-ын суурин төлөөлөгч хатагтай Беате Транкман, МҮХАУТ-ын дарга хатагтай М.Оюунчимэг болон КНХ-ын чиглэлээр манлайлан ажилладаг 4 компанийн төлөөллийг оролцуулан амжилттай үүсгэн байгуулсан. НҮБ-ын Даян Дэлхийн Гэрээ /UN Global Compact/-ний Монгол улс дахь сүлжээнээс санаачлан НҮБ-ын Глобал Компактын БНХАУ дахь сүлжээтэй хамтран туршлага солилцох уулзалтыг БНХАУ-ын Бээжин хотод, НҮБ-ын Монгол улс дахь төлөөлөгчийн газар, МҮХАУТ-тай хамтран бизнес эрхлэгчдэд Тогтвортой хөгжлийн зорилтууд, хариуцлагатай бизнесийн зарчмуудыг таниулах, мэдээлэх санал солих "Тогтвортой Хөгжлийн Зорилтууд ба Хариуцлагатай Бизнесийн Зарчим" уулзалтыг тус тус зохион байгуулсан.

Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг

Гадаад орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, 2 талын бизнес эрхлэгчдийг холбох зорилгоор 2015-2018 оны хооронд нийт 40 санамж бичгийг шинээр байгуулан хамтран ажиллалаа.

2015

НҮБ-ын Хүүхдийн сан
Швейцарь-Азийн худалдааны танхим
Мянмар улсын худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбоо
Унгар улсын худалдааны төв

Бразил Улсын Сан Паоло хотын худалдаа аж үйлдвэрийн танхим
Унгарын худалдаа аж үйлдвэрийн танхим
Унгарын Үндэсний худалдааны төв
Татарстаны худалдаа аж үйлдвэрийн танхим
БНХАУ-ын Шенян хотын Худалдааг Дэмжих Хороо
Юнь Нан хотын худалдааны танхим
БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааг Дэмжих Хороо
Монгол, Хятадын маргаан эвлэрүүлэн зуучлах төв
Дорнод аймаг дахь салбар танхим, БНХАУ-ын Манжуурын ХДХ, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын ХАУТ хооронд "noborder.ru" веб сайтын үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцож хамтран ажиллах гэрээ
БНСУ-ын Жижиг дунд бизнесийн корпорац
БНСУ-ын Олон улсын эдийн засгийн бодлогын институт
БНСУ-ын Аж үйлдвэрийн цогцолбор корпорац
БНСУ-ын худалдаа аж үйлдвэрийн танхим
Индонезийн худалдаа аж үйлдвэрийн танхим

2016

2017

Хятадын Нин Ся мужийн Худалдааг дэмжих хороо
Канад Монголын Худалдааны Танхим
БНСУ-ын Канвон мужийн аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих агентлаг
Эрхүүгийн худалдаа аж үйлдвэрийн танхим болон БНСУ-ын Эва

2017

эмэгтэйчүүдийн их сургуулийн инкубатор төв
ӨМӨЗО-ны Худалдааг дэмжих хороо
13 дахь удаагийн Монгол, Хятад, Оросын ХАҮТ-уудын нэгдсэн чуулганы үеэр
Хятад-Монголын салбар ХАҮТ-ууд 21 хамтын ажиллагааны санамж бичиг
байгуулсан

Хятадын Олон улсын худалдааг дэмжих хороо, ОХУ-ын худалдаа аж
үйлдвэрийн танхим
Монгол дахь Хятадын Хөрөнгө Оруулагчдын Зунхуа Нийгэмлэг
Тайваны гадаад худалдааны хөгжлийн зөвлөл (TAITRA)
Монгол, Өвөр Монголын Бизнесийн Ерөнхий Холбоо /ММСС/
Оросын ТББ “Бизнес Орос”
Соех Со., Ltd
Тюмений ХАҮТ
Хятадын худалдааг дэмжих хороо
Монгол-Шанхайн Бизнес Эрхлэгчдийн Хамтын ажиллагааны нийгэмлэг /
MSFIC/
Чехийн худалдаа аж үйлдвэрийн танхим
БНКаЗУ-ын Үндэсний танхим “Атамекен”
Казахстаны Гадаад худалдааны танхим
Автономит Ашгийн бус байгууллага “Гадаад худалдаа олон улсын эдийн
засгийн харилцааны хөгжлийн зөвлөл”
Туркийн Гадаад эдийн засгийн харилцааны зөвлөл
Тайпэй хотын импорт, экспортлогчдийн холбоо

Бизнес уулзалтууд

Томоохон бизнес уулзалтууд:

Монгол-Унгарын бизнес форум



Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн урилгаар Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбан / Victor Orban/ Монгол Улсад 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр айлчиллаа. Унгарын уулзалт өдөрлөгийг МҮХАҮТ-ын Их танхимд хоёр улсын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, Унгарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үзэсгэлэн худалдаа, ганцаарчилсан уулзалтууд зохион байгуулсан. Унгарын талаас **43** компаний **63** төлөөлөгч Монголын талаас **174** төлөөлөгч оролцов.

Монгол-Солонгосын бизнес форум



2016 онд Улаанбаатар хотноо болсон АСЕМ-ын 11 дэх дээд хэмжээний уулзалтад оролцсон БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэгийн манай улсад хийсэн айлчлалын хүрээнд 7 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол-Солонгосын бизнес форумыг МҮХАҮТ, БНСУ-ын Худалдаа, Аж үйлдвэрийн Танхим (KCCI) хамтран зохион байгуулав. Уг форумд Өмнөд Солонгосын 190 орчим төлөөлөл, Монголын 270 бизнес эрхлэгч, албаны хүмүүс оролцов.

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийх айлчлалын хүрээнд хийсэн бизнес форум

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийсэн айлчлалын хүрээнд хоёр орны хамтарсан бизнес форумд нийт 600 орчим төлөөлөгч оролцсон бөгөөд монголын 163 компанийн 299 төлөөлөгчид хятадын бизнес эрхлэгчидтэй 36 төрлийн 4.6 тэрбум долларын хөрөнгө оруулалт бүхий хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Өмнө нь болж байсан хамтарсан бизнес форумуудтай харьцуулахад хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй, өндөр үр дүнтэй бизнес форум болсон.



Зохион байгуулсан бизнес уулзалтууд

Хөрш орнуудтай хийсэн бизнес уулзалтууд:

БНХАУ

- Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийх айлчлалын хүрээнд Монгол-Хятадын бизнес уулзалт
- БНХАУ-д зохион байгуулагдсан Монгол-Орос-Хятадын гурван талт уулзалт
- БНХАУ-ын Нинся мужийн худалдааны танхимын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн МУ-д хийсэн айлчлал
- БНХАУ-ын Шанси мужийн Жанжье хотын төлөөлөгчдийн Монголын бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт Эрээн хотын Хилийн чөлөөт бүсийн танилцуулга уулзалт хурал

ОХУ

- "Орос-Монгол-бизнесийн шинэ хөгжил" бизнес форум
- Монгол-Оросын бизнес уулзалт, 2017
- Монгол-Оросын санаачилга 2018 арга хэмжээний хүрэн дэх бизнес форум
- ОХУ-ын Томск хотын ХАУТ-тай хамтран хүнс, мал, хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт
- ОХУ-ын Эрхүү хотын бизнес эрхлэгчдийн уулзалт

Бусад орнуудтай хийсэн бизнес уулзалтууд:

- Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНСУ-д хийх айлчлалын хүрээнд Монгол-Солонгосын бизнес уулзалт
- Монгол-Солонгосын бизнес уулзалт 2016, 2017

- Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон улсад хийх айлчлалын хүрээнд Монгол-Японы бизнес форум
- Монгол, Японы Засгийн газар, хувийн хэвшлийн худалдаа, хөрөнгө оруулалтын 7 дугаар зөвлөлдөх уулзалт
- Японы зах зээлд гарах боломж танилцуулга уулзалт
- Монгол Японы бизнес эрхлэгчдийн уулзалт
- Монгол Японы бизнесийн харилцааг идэвхижүүлэх нь сэдэвт семинар
- Турк улсын Ерөнхий сайдын Монгол улсад хийх айлчлалтай холбогдуулан Монгол Туркийн бизнес эрхлэгчдийн уулзалт
- Туркийн бизнес эрхлэгчдийн уулзалт
- Энэтхэгийн Ерөнхий сайдын Монгол улсад хийх айлчлалтай холбогдуулан Энэтхэгийн аж үйлдвэрийн танхимтай хамтран Монгол Энэтхэгийн эм, эмнэлэгийн салбарын бизнес эрхлэгчдийн уулзалт
- Монгол - Австрийн бизнес форум 2015, 2016, 2017, 2018
- Монгол-Тайваний Худалдаа, эдийн засгийн хамтарсан 14, 15, 16, 17 дахь уулзалт
- Монгол-Чехийн бизнес уулзалт 2015, 2016
- Монгол-Туркменистанын бизнес уулзалт 2015,
- БНГУ-ын Ерөнхийлөгч Иоахим Гаукийн төрийн айлчлалын хүрээнд Германы төлөөлөгчидтэй хийсэн уулзалт
- Монгол Казахстан хоёр улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалт
- Монгол-Казахстанын бизнес уулзалт 2016, 2017
- Хятад-Казахстаны "Хоргос" эдийн засгийн онцгой бүсийн талаар танилцуулга уулзалт
- Монгол-Татарстанын бизнес форум
- Монгол-Бразилын анхдугаар танилцах бизнес уулзалт
- КУБ улсын бизнес эрхлэгчдийн уулзалт
- Словак улсын бизнес форум
- Silk road International Chamber of Commerce гүйцэтгэх зөвлөлийн хурлын хүрэн дэх бизнес форум
- Олон улсын хөрөнгө оруулалтын банкны чуулга уулзалт




Аймгуудын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимууд

Хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд хүрч ажиллах, тэдгээрийг дэмжих зорилгоор 1998 онд анхны салбар танхимыг Дархан-уул аймагт байгуулж байснаас хойш 21 аймагт салбар танхимтай болж бие даасан үйл ажиллагаа явуулж, танхимын үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэж байна. Салбар танхимын ба танхимын чадавхыг бэхжүүлэх зорилгоор МҮХАУТ-ГХАУТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Экспортын зөвлөх үйлчилгээний төслүүдэд хамруулж ажилласан.

Нийт 21 аймагт ХАУТ-ууд 47 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Гишүүнчлэл

Аймгуудын ХАУТ нь 2018 оны байдлаар нийт 2115 гишүүдтэй байна.



Удирдлага, зохион байгуулалт

Аймгуудын ХАУТ нь бүх гишүүдийн хурлаар танхимын дүрмээ баталж, гишүүдээсээ тэргүүлэгчид болон даргаа сонгон үйл ажиллагаагаа явуулдаг.



Салбар танхимын тэргүүлэгч

1	Архангай	7
2	Баянхонгор	15
3	Баян-Өлгий	15
4	Булган	9
5	Говь-Алтай	11
6	Говь-Сүмбэр	9
7	Дундговь	9
8	Дархан	15

9	Дорноговь	11
10	Дорнод	9
11	Завхан	9
12	Орхон	7
13	Өвөрхангай	15
14	Өмнөговь	7
15	Сүхбаатар	9
16	Сэлэнгэ	9
17	Төв	15
18	Увс	15
19	Ховд	9
20	Хөвсгөл	15
21	Хэнтий	11
Нийт		231

Бодлогын өмгөөлөл, нөлөөлөл


21 аймгийн ХАУТ нь тухайн орон нутгийн бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэх хууль эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны байгууллагуудын удирдах зөвлөл, ажлын хороонд орж ажиллаж байна. 2018 оны байдлаар Аймгийн төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зөвлөлд 11, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 5, төр хувийн хэвшлийн зөвлөлд 3, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн орон тооны бус зөвлөлийн гишүүн 5, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 4, татварын маргаан таслах зөвлөлд 6, мэргэжилтэй ажилтан бэлтгэх политехник коллежийн ажлын хэсгийн зөвлөл 4 аймгаас орж ажиллаж байна.


Үзэсгэлэн худалдаа

2015-2018 онуудад аймгуудын ХАУТ дангаараа болон орон нутгийн засаг даргын тамгын газартай хамтарсан Цагаан сар, Намрын түншлэл болон бүс нутгийн үзэсгэлэнгүүд нийт 114 үзэсгэлэн зохион байгуулж 8267 ААН хувь хүн оролцож 7.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

БНХАУ, ОХУ-д зохион байгуулагдсан 30 үзэсгэлэнд орон нутгийн 1605 ААН оролцуулж 4.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

Гадаадад зохион байгуулсан үзэсгэлэнд оролцсон орон нутгийн бизнес эрхлэгчдийн тоо





Сургалт, арга хэмжээ

Орон нутгийн засаг даргын тамгын газар, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр уулзалт арга хэмжээ, сургалтуудыг байнга зохион байгуулдаг.

Хангайн бүсийн чуулган-2017

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, “Конрад-Аденауэр-Сан”, Хөвсгөл аймгийн ЗДТГ болон МҮХАҮТ хамтран “Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2017” арга хэмжээг Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2017 оны 10-р сарын 12-13-ны хооронд зохион байгуулсан.

Чуулга уулзалтад Хангайн бүсийн Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Архангай, Баянхонгор зэрэг зургаан аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар болон холбогдох албаны хүмүүс оролцсоноос гадна Улаанбаатар хотоос ЗГХЭГ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Үндэсний хөгжлийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн батлан даалтын сан, Азийн сан, Монголын аялал жуулчлалын холбоо болон бизнесийн байгууллагуудын төлөөллүүд оролцов.

Чуулганы хүрээнд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо-Бүсчилсэн хөгжил”, “Хангайн бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь”, “Хангайн бүсийн

ЖДҮ-ийг хөгжүүлэх нь”, “Хангайн бүсийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх нь” зэрэг үндсэн дөрвөн хэлэлцүүлэг өрнүүлсэн бол чуулганы хоёр дахь өдөр “Хангайн бүсийн хамтын ажиллагаа, цаашдын алхам” хэлэлцүүлгээр оролцогч аймгууд салбарын бодлогыг бүсийн хэмжээнд хэрхэн уялдуулж, хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсон.

Төвийн бүсийн Өрсөлдөх чадварын чуулган-2018



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс “Төвийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2018 - Өнөөдрийн шийдвэр, Ирээдүйн хөгжил” арга хэмжээг 2018 оны 10-р сарын 26-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгуулсан. Тус чуулга уулзалтын зорилго нь Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Говь-Сүмбэр аймгууд өрсөлдөх чадварын үзүүлэлтэд тулгуурлан урт хугацаанд бодлогын түвшинд хамтран ажиллах боломж, хөгжлийн төсөл хөтөлбөрийн уялдааг сайжруулах талаар төр, хувийн хэвшлийн төлөөллүүд хэлэлцлээ. Тус чуулганд МҮХАҮТ-аас орлогч дарга М.Сарандаваа, МҮХАҮТ-ын Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Говь-Сүмбэр, Булган аймаг дахь салбар танхимын дарга нар оролцож, өөрсдийн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтэд тулгуурлан урт хугацаанд бодлогын түвшинд хамтран ажиллах боломж, хөгжлийн төсөл, хөтөлбөрийн уялдааг сайжруулах талаар хэлэлцсэн.

Ойн арга хэмжээ

2018 онд МҮХАУТ-ын Дархан-Уул аймаг дахь салбар танхимын 20 жилийн ойн, Завхан аймаг дахь салбар танхимын 15 жилийн ойн тус тус болж өнгөрсөн.



Судалгаа

МҮХАУТ-ын “Бизнесийн орчны судалгаа”, “Бизнесийн итгэлийн индекс”, “Хүнд суртлын индекс”, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн “Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа”-г гаргахад орон нутгийн бизнес эрхлэгчдийг хамруулах ажлыг 21 аймаг дахь ХАУТ-ууд хийж гүйцэтгэсэн.

Үйлчилгээ


Тайлант хугацаанд Салбар танхимууд 13 үйлчилгээг гишүүддээ хүргэсэнээс:

- 10,000 гаруй орон нутгийн аж ахуйн нэгжүүд, иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж,
- 400 гаруй аж ахуйн нэгжүүдэд бизнес зөвлөгөө өгч,
- бие даан Арбитрийн 8 хэрэг хянан шийдвэрлэн,
- 6000 гаруй иргэдийг үзэсгэлэнд оролцуулан,
- 224 гарал үүслийн гэрчилгээ олгон,
- 270 экспертизийн үйлчилгээ үзүүлж,
- 1000 гаруй аж ахуйн нэгжийн 2100 иргэн сургалтанд хамрагдаж

мөнгөн дүнгээр нийт 357,5 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Орон нутаг дахь салбар танхимууд

2017-2018 орон нутгийн салбар танхимаас олгосон гарал үүслийн гэрчилгээний тоо



Төсөл хөтөлбөрүүд

МҮХАУТ-ГХАУТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл



МҮХАУТ, ГХАУТХ хамтран ХБНГУ-ын Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Яамнаас санхүүжилттэй Монголын бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр Архангай аймагт хонины ноос, Увс аймагт чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл 2015 оны 09 дүгээр сараас 2018 оны 8 дугаар сарын хооронд 3 жилийн хугацаатай хэрэгжсэн. 2018 оны 4 дүгээр сард ProValue төслийн I үе шатны үнэлгээ хийж амжилттай хэрэгжсэн гэж дүгнэн төслийн II үе шатыг 2018 оны 9 дүгээр сарын 1 - ээс 2021 оны 8 дугаар сарын 31 хүртэл хэрэгжүүлэхээр болсон.

Төслийн хүрээнд төсөлд хамрагдсан үйлдвэрлэгч нарыг чадавхижуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулсны дотор олон улсын экспертүүдийг урьж Увс аймагт "Чацарганы бүтээгдэхүүн хөгжүүлэлт", Архангай аймагт "Эсгий бүтээгдэхүүний загварыг сайжруулах" сургалтыг зохион байгуулсан. Мөн Увс аймгийн чацарганы кластер багийнханыг ХБНГУ-д туршлага судлах аялалд хамруулсан.

Монголын Худалдааг Дэмжих Төсөл



Монголын худалдааг дэмжих төслийг хэрэгжүүлэх хүрээнд 2018 онд "ЕХ-ны худалдааны өдрүүд" арга хэмжээг 250 бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.

Монгол улсын экспортын орчны болон экспортын чиглэлийн кластер хөгжүүлэх судалгааг олон улсын болон үндэсний судлаачдын баг бүрдүүлэн хийсэн. Судалгааны хүрээнд нийт 10 орчим салбарын 100 гаруй экспортлогчидтой салбарчилсан уулзалтууд хийж экспортын чиглэлийн ноос, гоо сайхан, чацарганы тос, арьс шир 4 салбарыг сонгон кластер байгуулах ажлыг эхлүүлсэн.

Бизнес эрхлэгчдийг мэдээллээр хангах үүднээс TRAM төслийн санхүүжилтээр "Экспортын замын зураглал", "АТА карнет системийн гарын авлага", "ЕХ-ны ХЕС-ийн танилцуулга", "Төсөл боловсруулах гарын авлага", "Бизнес саналууд" зэрэг гарын авлагуудыг боловсруулан хэвлүүлэв.

Худалдаа Хөнгөвчлөх Хорооны гишүүн байгууллагуудын төлөөлөл бүхий багийг Гүрж улсын төрийн байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний туршлагатай танилцуулан, Гүржийн ХАУТ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.



European Bank for Reconstruction and Development

EBRD Экспортын зөвлөх үйлчилгээний төсөл

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран Экспортын зөвлөх үйлчилгээний 3 шаттай арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд :

I шат: 5 сарын 1-д Экспортын зөвлөх үйлчилгээ сургалтыг зохион байгуулсан. Сургалтын хүрээнд 40 экспортлогч компаниар анкет бөглүүлэн EBRD олон улсын зөвлөх Ровертоос зөвлөгөө авахуулахаар өгсөн. Тус сургалтад нийт 56 бизнес эрхлэгчид оролцов.

II шат: 5 сарын 21-д EBRD оффис дээр 2 дугаар шатны арга хэмжээ болох Robert экспертэй онлайн сургалт хамтран хийсэн. Сургалтад өмнөх шатнаас сонгогдсон 20 орчим экспортлогч компаниуд оролцсон. Robert эксперт экспортын бэлэн байдлын үнэлгээ хийх талаар зөвлөгөө өгсөн.

III шат: Онлайн сургалтад хамрагдсан 20 гаруй компанид Robert эксперт Монголд ирэн үнэгүй зөвлөгөө биечлэн өгсөн.

"Монголд үр дүнтэй, бизнес гишүүнчлэлтэй холбоодыг хөгжүүлэх төсөл"

ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр Зөвлөх үйлчилгээний "Монголд үр дүнтэй, бизнес гишүүнчлэлтэй холбоодыг хөгжүүлэх төсөл"-д Сүхбаатар, Говь-Алтай, Хэнтий аймгууд дахь салбар танхимууд хамрагдаж гишүүд бизнес эрхлэгчдэд хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор байгууллагын стратеги, маркетингийн болон бизнесийн төлөвлөгөө боловсруулсан бөгөөд ажилтнуудыг чадавхижуулах чиглэлээр төрөл бүрийн сургалтуудад хамрагдсан.

Дэлхийн банкны экспортыг дэмжих төсөл



Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн ассоциаци (ОУХА)-ын хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу 14,300,000 Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-тэй тэнцэх хөнгөлөлттэй зээлийн төсөл нь уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхийг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготойгоор 2017 оноос эхлэн хэрэгжиж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд МҮХАУТ-ын зүгээс мэдээлэл хүргэх, сургалт явуулах, судалгаа хийх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Нийгмийн түншлэл төсөл



Харгалуулалт: **giz** Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH


Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)-тэй хамтран “Нийгмийн түншлэл” төслийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

“ХБНГУ-ын хос систем дэх үйлдвэрийн дадлагын чанарыг хангах нь” зөвлөмж

МҮХАУТ-ын гишүүн байгууллагын 150 хүнээс “Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш ажиллаж буй өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгаа” авч, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Үйлдвэрлэлийн дадлага сургалтын чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас, 3 төрлийн шторк, 2 төрлийн богино хэмжээний кино зэрэг сурталчилгааны материалыг боловсруулав.

- ААНБ болон МБСБ-ын хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллийн бааз бий болгох зорилгоор МҮХАУТ-ын дэргэд Нэг цэгийн үйлчилгээг байгуулан ажиллаж байна.



The Asia Foundation

Азийн сан, КОЙКА ОУБ, НЗДТГ-тай хамтарсан бизнес эхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төсөл

МҮХАУТ-аас Монгол дахь Азийн сангийн суурин төлөөлөгчийн газар, Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага KOICA, НЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төслийг 2016-2018 оны хооронд хэрэгжүүлэв. Уг төслийн хүрээнд сургалт, уулзалт арга хэмжээ, зөвлөх үйлчилгээ гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 51 удаагийн сургалтанд 1639, 7 удаагийн уулзалтанд 345 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцсон бол зөвлөн туслах үйлчилгээнд 17 чиглэлээр 159 хүнийг хамруулсан байна.

Ардчилсан оролцоотойгоор Төрийн Албанд Сайн Засаглал, Ил тод Байдлыг Бэхжүүлэх нь төсөл

Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн сангийн хэрэгжүүлж буй Ардчилсан оролцоотойгоор Төрийн Албанд Сайн Засаглал, Ил тод Байдлыг Бэхжүүлэх нь төслийн (STEPS) хүрээнд МҮХАУТ нь 2017 оноос эхлэн бизнес эрхлэгчдийн авлигын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг Авлигатай тэмцэх газартай хамтран боловсруулж уг хөтөлбөрөөр 19 компанийн 520 бизнес эрхлэгч, ажилтнуудад сургалт явуулсан.

McKinsey and Company

McKinsey & Company

Менежментийн зөвлөх үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч McKinsey & Company хамтран

Монголын компаниудын үйл ажиллагаанд байгууллагын хөгжлийн индекс (ONI) үнэлгээг хийлгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг хөтөлбөрт нийт 5 компанийг төлбөрийн 50%-ийн хөнгөлөлтэй нөхцөлөөр хамруулахаар болсон.

Органик Монгол хөтөлбөр



МҮХАУТ-ын санаачилгаар хувийн хэшлийн томоохон төлөөллүүд болох Хас банк, Капитал банк, Бишрэлт групп, Петровис, Макс групп, Энержи ресурс ХХК хамтран компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд анх удаа Органик монгол бичил зээлийн хөтөлбөрийг 2009 оноос хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь анх газар тариалангийн төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан бол 2017 оноос эхлэн хамрах хүрээгээ өргөжүүлж органик, тогтвортой хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн хэмнэлттэй, алдагдал хаягдал багатай үйлдвэрлэлийн төслүүдэд дэмжлэг үзүүлж эхэлсэн.

Хөтөлбөрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр тухайн жилд аль орон нутгийн, ямар чиглэлийн төслүүдийг дэмжих талаар шийдвэр гарсны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал 2015-2018 онд Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан, Төв, Хөвсгөл аймгуудын нийт 108 төсөлд 1,1 тэрбум төгрөгийн зээл олгосон.



Эксперттүүд:

МҮХАУТ дээр Жижиг дунд үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгөх, чадавхжуулах, улс хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2015-2018 оны хооронд Японы ЖАЙКА, Солонгосын КОТРА, Канадын Юниатера зэрэг байгууллагуудаас экспертүүд ирж ажилласан. Тухайлбал: ЖАЙКА-ийн шугамаар МҮХАУТ дээр ажилласан Масуда Такуми нь орон нутгийн болон дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүний сав баглаа боодол борлуулалтанд хэрхэн нөлөөлөх талаар мэдээлэл, зөвлөгөө, сургалтуудыг тогтмол хийж, Япон улсад зохион байгуулагддаг үзэсгэлэнгүүдэд хэрхэн оролцох талаар зөвлөгөө өгөх, зохион байгуулагч нартай холбох зэргээр амжилттай ажилласан.



ЧИГЛҮҮЛЭХ

Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах

ЧИГЛҮҮЛЭХ

Сургалт

МҮХАУТ-аас Гишүүд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор Гадаад худалдааны академиас урт болон богино хугацааны сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 10000 орчим хүнийг сургалтанд хамруулсан байна.



1. Гадаад худалдааны менежер бэлтгэх сургалт

“ГАДААД ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР” бэлтгэх “Пүрэв”, “Бямба” гарагийн болон Эчнээ ангийн 1 жилийн РОМБО, ДИПЛОМ олгох сургалтуудыг зохион байгуулж 232 хүнийг хамруулав. Сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, 13 модуль 410 цагийн сургалтыг онлайн болон танхимаар зохион байгуулж байна.

2. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт

Компанийн тухай хуулийн 75.8-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн

нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна” гэсэн хуулийн заалтын хүрээнд Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтыг Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулж, 413 хүнийг хамруулсан байна.

3. Захирлуудад зориулсан CEO сургалт


Компанийн тогтвортой байдлыг хангах, бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, ажилтнуудынхаа бүтээмжийг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад зориулсан 16 цагийн захирлуудад зориулсан CEO сургалтыг зохион байгуулж, 133 хүнийг хамруулсан байна.

4. Даргын туслах бэлтгэх сургалт

Даргын туслах бэлтгэх сургалт нь бичиг баримтыг стандартын дагуу боловсруулах, албан тоот, тушаал төлөвлөх, албан захидлыг монгол, англи хэл дээр төлөвлөх, бизнесийн харилцааны талаарх цогц мэдлэг мэдээлэл олгох зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулж байна. Аж ахуй нэгж байгууллагын 180 гаруй даргын туслахыг энэхүү сургалтад хамруулсан байна.

5. Богино хугацааны болон захиалгат сургалт

МҮХАУТ-ын гишүүд, бизнес эрхлэгчдэд зориулан 50 гаруй төрлийн сэдвээр богино хугацааны болон захиалгат сургалтуудыг зохион байгуулж байна. Тухайн сэдвүүдээс сонгон өөрийн байгууллага дээрээ сургалт авах боломжтой бөгөөд зөвхөн танай байгууллагад хэрэгцээтэй байгаа сэдвүүдээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж захиалгат сургалтыг зохион байгуулж байна. 2016-2018 оны хооронд Богино болон захиалгат сургалтанд нийт 8660 орчим хүнийг хамруулсан.



Судалгаа

1. Бизнесийн орчны судалгаа



Монголын бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээнүүд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог тодорхойлох зорилгоор 2017 онд МҮХАҮТ –аас МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран бизнесийн орчны судалгааг үндэсний хэмжээнд явуулсан. Энэхүү судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн 2010 аж ахуй нэгжийг хамруулсан. Монголын бизнесийн орчны үнэлгээг 5 ерөнхий, 12 дэд бүлгийн 88 асуулгаар 1-7 онооны үнэлгээгээр үнэлүүлэхэд 3,03 буюу хангалтгүй гэсэн үнэлгээ гарсан.

2. Бизнесийн итгэлийн индекс



Энэ судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, түүний өөрчлөлтийн талаарх хүлээлт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаар бизнес эрхлэгчид, иргэдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчинд таатай, таагүй нөлөө үзүүлж буй төрийн бодлого шийдвэр, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлууд зэрэг эдийн засаг бизнесийн орчны чухал үзүүлэлтүүдээр судалгаанд оролцогчдын саналыг тоймлон гаргахыг зорьдог.

3. Хүнд суртлын индекс



“Хүнд суртлын индекс” судалгаагаар төрийн үйлчилгээний цаг хугацаа, зардал, баримт бичгийн тоо зэрэг бодит үзүүлэлтүүдэд тулгуурлан бодитой тооцож гаргах зорилгоор Азийн сангийн дэмжлэгтэйгээр аргачлалыг шинэчлэн боловсруулж явуулсан. Хүнд суртлын индексийн судалгааг Улаанбаатар хот болон орон нутгийн бизнес эрхлэгчдээс ганцаарчилсан ярилцлага авах хэлбэрээр энэ оны 10-11-р сард явуулж нийт 1910 аж ахуйн нэгжийг хамруулан төрийн 54 байгууллагын давхардсан тоогоор 2009 үйлчилгээг үнэлүүлсэн. Хүнд суртлын ерөнхий индекс 2018 онд 2.51 гэж үнэлэгдсэн нь 2015 оны 2.72 гэсэн индексээс буурсан дүнтэй гарсан бөгөөд харин төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлын дундаж индекс нь 2018 онд 3.29 гэсэн дүнтэй гарсан.

4. Монгол улсын татварын тогтолцооны шинэчлэл, татварын оновчлол



МУ ын татварын системд шинэчлэл хийх үндэс суурийг тавих, татварын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судалгаа, шинжилгээний дэвшилтэт арга, загваруудыг ашиглан хийж дүгнэлт гарган, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилготойгоор МУИС-ийн бизнесийн сургуулийн судлаачдын багтай хамтарсан судалгааг 2017 онд хийсэн.

Судалгааны хүрээнд бодлого боловсруулагчид төсвийн орлого, зарлагын бүтэц татварын оновчлолд судлаачдын санал болгож буй хосолсон загварыг ашиглахыг санал болгон тооцооллын програм хангамжийг ашиглах зааврын хамт гаргасан. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн их байлгах оновчтой бүтцийг тодорхойлон багцын онолын загварыг дэвшүүлсэн.

5. Төрийн өмчит компаниудын засаглалын тойм судалгаа

Энэхүү тойм судалгаагаар төрийн өмчит 45 байгууллагын 2017 оны ашиг орлогын мэдээ, байршил, ТУЗ-ийн гишүүд болон хараат бус гишүүдийн мэдээллийг тус тус гаргасан. Нийт 278 ТУЗ болон хараат бус гишүүн байснаас давхардсан тоогоор дараах байгууллагуудын төлөөлөл төрийн өмчит компаниудын ТУЗ-д орж ажиллаж байгаа бөгөөд байгууллагаар нь харуулбал:

- Эрчим хүчний яамны 5 албан хаагч /1-3 компани/
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 5 албан хаагч /1-2 компани/
- Уул уурхай, хүнд үйдвэрийн яам- 1 албан хаагч /1-2 компани/
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар 2 албан хаагч /1-2 компани/
- Сангийн яамны 2 албан хаагч /1-3 компани/


Ном гарын авлага

МҮХАҮТ-аас бизнес эрхлэгчдэд зориулсан Бизнесийн боловсрол цувралыг гаргадаг бөгөөд 2015-2018 онуудад шинээр 6 гарын авлага гаргасан.

- АТА Карней
- Монголын эдийн засаг, гадаад худалдааны Цагаан ном 2015
- Бизнес санал 2015



- Safety Book 2016



- Экспортлогчдын замын зураг
- Арбитрын эрх зүйн актын эмхтгэл
- Европын холбооны шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий систем "EU GSP+" гарын авлага
- БНХАУ-ын зах зээлд нэвтрэх боломж
- Гадаад худалдааны гэрчилгээ олгох гарын авлага

МҮХАҮТ-ын Мэдээллийн хэрэгслүүд

Бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй мэдээлэл бэлтгэж түгээх, тэдний дуу хоолойг илэрхийлэх, Танхимын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд эдийн засаг, санхүүгийн боловсрол олгох зорилгоор "Бизнес таймс" 7 хоног тутмын сонин, "Бизнес ба хөгжил" монгол сэтгүүл, "Invest Pro Mongolia" англи сэтгүүлийг эрхлэн гаргаж байна. Мөн Танхимын албан ёсны веб сайт болон фэйсбүүк хуудсыг тогтмол хөгжүүлэн хөтөлж байна.



www.mongolchamber.mn


2017 онд Танхимын веб сайтыг шинэчилж Монгол, Англи, Орос, Хятад хэл дээр нэгдсэн нэг удирдлагын системтэй болгон хөгжүүлсэн ба 2018 оны байдлаар өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад сайтын хандалт 25 хувиар өссөн.



<https://www.facebook.com/mongolchamber/>

Фэйсбүүк хуудасны дагагч 30 хувиар өсч 25600 болсон байна.

“Бизнес таймс” сонин



Бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй мэдээлэл бэлтгэж түгээх, тэдний дуу хоолойг илэрхийлэх, Танхимын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд эдийн засаг, санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Бизнес таймс” 7 хоног тутмын сонин 1995 оноос 25 дахь жилдээ гарч байна.

Тус сонины хүртээмжийг нэмэгдүүлэх, сэдэв агуулгын чанар, далайцыг сайжруулах зорилгоор 2017 оны 9 дүгээр сарын 1-нээс онлайн хэлбэрт шилжүүлсэн бөгөөд www.businesstimes.mn сайтад тогтмол байршиж, Танхимын пэйж болон бусад онлайн сувгаар түгээгдэж байна.

2015-2018 оны хугацаанд “Бизнес таймс” сонины нийт 116 дугаар цаасаар, 42 дугаар онлайнаар гарч, сайтын 6 категори, 14 төрөлд нийт 700 гаруй контент ороод байна.

“Бизнес ба хөгжил” сэтгүүл



Бизнес, эдийн засаг, санхүүгийн төрөлжсөн хэвлэл болох “Бизнес ба хөгжил” сэтгүүл нь МҮХАУТ-ын дэргэд 2006 оноос улирал тутамд гарч, гишүүн ААН-д тараалтаар болон олон нийтэд захиалгаар хүрч байна. 2015-2018 онд уг сэтгүүлийн нийт 15 дугаар нийтлэлийн бодлогын дагуу, тухайн цаг үеийн голлох мэдээлэлд тулгуурлан гарсан байна. Энэ хугацаанд 6 дугаарыг Танхимаас онцлох үйл явдал, бизнес форум, айлчлал зэрэг арга хэмжээнд тусгайлан зориулж гаргасан.

“Invest Pro Mongolia” сэтгүүл



Монголын бизнес, татвар, хөрөнгө оруулалтын орчныг гадаадынханд танилцуулах, дотоодын зах зээлд хөл тавих сонирхолтой гадаадын иргэдэд мэдээлэл хүргэх зорилготой “Invest Pro Mongolia” сэтгүүл 14 дэх жилдээ улирал тутамд гарч байна. Тус сэтгүүл 2015-2018 онд нийт 14 дугаар зорилтот сэдвийн хүрээнд гарч, уншигчдын хүртээл боллоо.



МАНЛАЙЛАХ

Танхимын засаглал, менежементийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх

МАНЛАЙЛАХ

МҮХАУТ нь нийт 111 ажилтан, 6 газар, 2 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнийг графикаар харуулбал:



Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувь хүний хөгжилд чиглэсэн дотоодын сургалт, мэдлэг мэдээллээ хуваалцах уулзалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй ажилтныг, ажлын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Япон, Хятад, Сингапур, Тайвань, Тайланд, Энэтхэг, Солонгос зэрэг улс орнуудад зохион байгуулагдсан дунд болон богино хугацааны сургалт семинаруудад давхардсан тоогоор 70 гаруй ажилтныг хамруулсан.

Мөн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн "Тэнгэр даатгал" ХХК-тай хамтран "Эрүүл мэндийн даатгал", "Гэнэтийн ослын даатгал"-ын гэрээг анх удаа байгуулж эрүүл мэндийг даатгалын үйлчилгээнд хамруулсан.

Байгууллагын нөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, ажилтанд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг тодруулах, түүнийг арилгах болон засан сайжруулах арга зам, нөхцөл байдлыг үнэлэх, ажилтан болгоны санаа бодлыг сонсох зорилгоор 17 асуулга бүхий судалгаа авч нийт ажилтнуудын 72 хувь хамрагдсан.


Танхимын дотоодод хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

1. Green HR

"Бизнетворк консалтинг" ХХК-тай 2015 оны 11 сараас эхлэн бэлтгэл ажлууд хийгдэж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, байгууллагын үйл ажиллагааны урсгалыг диаграммыг зураглаж, ажил үүргийн хуваарь тодорхой болгох, карьер хөгжил, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ /KPI/, ажлын үр дүнг хэмжигдэхүйц болгохоор зорьж Хүний нөөцийн Green HR системийг нэвтрүүлсэн.

2. Мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн систем

2015 оноос эхлэн үйл ажиллагаагаа түргэн шуурхай болгох, шийдвэр гаргалтыг хурдасгах, гишүүдэд чиглэсэн стратегийг дэвшилтэт технологи ашиглан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сан дээр үндэслэн дүн шинжилгээ, анализ хийх, гишүүн болон үйлчлүүлэгчдийн талаарх бүх мэдээллийг төвлөрүүлэх, гишүүдээс ирсэн санал гомдлыг үйл ажиллагаандаа бодитоор тусгах, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх зорилгоор "Мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн систем"-ийг үе шаттайгаар нэвтрүүлж 25 модуль, 211 хэсэгтэйгээр хөгжүүлэн 2018 онд бүрэн ажиллагаанд оруулсан.



3. Inside Out

МҮХАУТ-ын одоогийн нөхцөл байдлыг үнэлэх, сайжруулалт хийх төлөвлөгөө боловсруулах зорилгоор "Дотоод нөөц бололцоогоо ашиглах нь" Inside Out 1.0 төслийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд ажилтнуудыг чадавхижуулах багаар ажиллах дасгал сургалтуудыг 5 удаа зохион байгуулж, танхимын ажилтнуудтай уулзаж дүгнэлт гаргасан.

Мөн төслийн 2 дах үе шат "Inside Out 2.0" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд МҮХАУТ дээр Өөрийн удирдлагат багуудыг бий болгох, Танхимын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх гэсэн 2 зорилтын хүрээнд ажиллаж Борлуулалт, Харилцаа холбоо, Бүтээгдэхүүний багц, Хүний нөөц, Салбар танхимын үйл ажиллагааг дэмжих гэсэн 5 өөрийн удирдлагат баг байгуулсан ба Танхимын бүтэц зохион байгуулалтын шинэ загвар төслийг танхимын гүйцэтгэх удирдлага, ажилтнуудтай хамтарч гарган, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийсэн.



4. Brandbook

МҮХАУТ-ын нэр хүнд, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах зорилгоор 2016 онд Танхимын брэндбүүк гаргасан. Энэ ажлын хүрээнд танхимын лого, бланк, танилцуулга, хэвлэмэл материалууд гэх мэт байгууллагын өнгө төрх, нэр хүндийг илэрхийлэх загварыг баталж үндэсний танхимаас гадна 21 аймаг дахь ХАУТ-д нэвтрүүлсэн.



5. ICC Chamber Check Diagnostics

МҮХАУТ-аас 2017 онд Олон улсын худалдааны танхим (ICC)-ын "Chamber Check Diagnostics" хэрэгслийг ашиглан өөрсдийн үйл ажиллагаандаа үнэлгээ өгсөн. Тус хэрэгслийг ашигласнаар танхимууд өөрсдийн үйл ажиллагаа нь анхан шатны, хөгжиж буй, хөгжсөн, хүчтэй, манлайлагч гэсэн 5 түвшний аль түвшинд ажиллаж буйгаа тодорхойлох боломжтой байдаг ба МҮХАУТ нь хөгжсөн танхим гэсэн үнэлгээ авав.



6. МҮХАУТ-ын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг төсөл


2016 онд Олон улсын худалдааны төв (ITC)-өөс МҮХАУТ-ын үйл ажиллагаан дээр Бэнчмаркинг буюу

харьцуулсан үнэлгээг хийсэн. Тус үнэлгээ нь нийт 225 шалгуур үзүүлэлтээр Манлайлал болон чиглэл, Үр дүн болон хэмжилт, Нөөц болон үйл явц, Бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлт гэсэн 4 үндсэн гол үзүүлэлтэнд оноо өгдөг үнэлгээ бөгөөд МҮХАУТ нь 46,43% буюу дэлхийн бусад танхимуудтай харьцуулахад дундаж зэрэглэлд үнэлэгдсэн.

Уг үнэлгээг хийх хугацаанд ОУХТ-ийн экспертүүд МҮХАУТ-ын давуу болон сул талуудыг тодорхойлсон ба үр дүн дээр нь үндэслэн үндсэн 4 зорилт бүхий Танхимын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг (PIRM) төслийг 2017-2018 оны хугацаанд хэрэгжүүлсэн.

Төслийн үр дүнд МҮХАУТ дээр 2018 оны 11-р сард дахин хийгдсэн Харьцуулсан үнэлгээгээр 57,84% гэсэн үнэлгээг аваад байна.

МҮХАУТ	2016	2018	Өсөлт
Манлайлал болон чиглэл	56,4	60,43	7%
Нөөц болон Үйл явцууд	48,71	60,68	25%
Бүтээгдэхүүн Үйлчилгээний хүргэлт	40,9	54,01	32%
Хэмжилт ба Үр дүн	36,69	56,25	53%



7. Чанарын удирдлагын ISO 9001

МҮХАУТ Дэлхийн 140 гаруй оронд 840 салбар, 320 гаруй лабораторитай, хяналт, шалгалт, үнэлгээний дэлхийд тэргүүлэгч байгууллага Швейцарийн Женевт төвтэй "SGS" компаниар аудит хийлгэж ISO 9001:2015 шаардлагыг хангаж, баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан.

МҮХАУТ-ын чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээ нь: Бизнесийг дэмжих ба бодлогын өмгөөллийн үйлчилгээ, үүнд бизнес арга хэмжээ, судалгаа, үзэсгэлэн, сургалт, гадаад худалдааны баримт бичгүүд ба ногоон шошго олгох, бизнесийн маргааны эвлэрүүлэн зуучлал ба арбитрайн шүүх



МУХАҮТ-аас төлөөлөн оролцдог зөвлөл, хороо, ажлын хэсгийн жагсаалт

(2018.12.31-ны байдлаар)

№	Харьцдаг байгууллагууд	Зөвлөл, хороо	Ажлын хэсэг
1	Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар		Монгол улсын Засгийн газарт тэтгэврийн шинэчлэлийн талаар чиглэл өгөх, санал боловсруулах ажлын хэсэг
2	Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо		Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг бэлтгэх ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг
3	Монгол Улсын Их Хурлын байнгын хороо		Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн дэд ажлын хэсэг
4	Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо		Банкны тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсэг
5	Монгол Улсын Засгийн газар	Эдийн засгийн бодлогын зөвлөл	
6		Тогтвортой хөгжлийн үндэсний хороо	
7		Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл	
8		Үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий төв комисс	
9		Замын үүд, Эрээний боомтыг түшиглэн хил дамнансан чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	
10		Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй зөвлөл	
11		Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл	
12	Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөл		
13	Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны дэд дарга	
14		"Эдийн засгийн чуулган" арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	
15		Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	
16		Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо	
17		Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга төслийн удирдах хороо	
18	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээний дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах комисс	

19	Гадаад Харилцааны Яам	"Монголын мянганы сорилтын сан"-гийн удирдах зөвлөл	
20		Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл	
21			Монгол улс Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсэг
22			"Монгол-Хятадын Экспо" арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг
23		Монгол Оросын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан технологийн засгийн газар хоорондын комисс	
24		Монгол Оросын хил худалдаа бүс нутгийн хамтын ажиллагааны дэд комиссын ажлын хэсэг	
25		Монгол – Польш худалдаа эдийн засгийн комисс	
26		Монгол – Латви худалдаа эдийн засгийн комисс	
27		Монгол- Киргиз худалдаа эдийн засгийн комисс	
28		Монгол-Казакстан худалдаа эдийн засгийн комисс	
29		Монгол Чех худалдаа эдийн засгийн комисс	
30			Монгол улс, БНСУ хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, нөхцлийг судлан, санал, дүгнэлт гаргах судалгааны баг
31			ГХЯ-ны Дэлхийн Монголчууд ажлын хэсэг
32			Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийн ажлын хэсэг
33		Сангийн яам	Гаалийн тарифын зөвлөл
34	Хилийн боомтын үндэсний зөвлөл		
35			Монгол улсын татварын орчинд дүн шинжилгээ хийж, татварын тэгш, шударга байдлыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, татварын орлогод нөлөөлөх, эсхүл орлого нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулах ажлын хэсэг
36			"Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээл" төслийн удирдах хороо
37			Санхүүгийн түрээс /лизинг/-ийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл бэлтгэх, судалгаа шинжилгээ хийх зорилго бүхий ажлын хэсэг
38			Экспортыг дэмжих төслийн ажлын хэсэг
39	Хууль зүй, дотоод хэргийн яам		
40			Оюуны өмчийн багц хуулиудын шинэчлэлийн ажлын хэсэг
41			Дампуурлын хуулийн төслийн ажлын хэсэг





42	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		Монгол-Японы засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан худалдаа, хөрөнгө оруулалтын 8 дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах ажлын хэсэг
43		Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөл	
44			Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
45			"Жижиг дунд үйлдвэрийг дэмжих" хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг
46			Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсэг
47		Тендерийн үнэлгээний хороо	
48			ЗГ-ын Худалдааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг
49		Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн удирдах хороо
50	Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний Зөвлөл		
51			Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
52			Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг
53	Ази, Номхон далайн орнууд дахь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх төслийн удирдах хороо		
54			Мэргэжлийн боловсролын сургалтын бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг
55	Зам, тээврийн хөгжлийн яам		Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах чиглэлээр судалгаа хийж, зураглал гарган ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг
56	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн дэд ажлын хэсэг
57			Газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлыг шинэчлэн тогтоох ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
58	Эрчим хүчний яам		Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг
59			Эрчим хүч хэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг
60	Монголбанк	Хяналтын зөвлөл	
61	Хөгжлийн банк	ТУЗ-ын Хараат бус гишүүн	

62	Үндэсний хөгжлийн газар		Баялаг бүтээгчдийг дэмжих багц бодлого, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг
63	Үндэсний хөгжлийн газар		Монгол улсын үндэсний сайн дурын илтгэлийг бэлтгэх ажлын хэсэг / Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр/
64	Үндэсний хөгжлийн газар	Монгол улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах тухай орон тооны бус зөвлөл	
65	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	Орон тооны бус гишүүн	
66			Өрсөлдөөний тухай хуулийн ажлын хэсэг
67	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар		Үндэсний Цахим нэг цонхны бизнесийн процессын ажлын хэсэг
68	Стандартчилал, хэмжил зүйн газар	Цахилгаан техникийн үндэсний хороо	
69		Стандартчиллын үндэсний зөвлөл	
70		Чанарын удирдлагын техникийн хороо	
71		Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн техникийн дэд хороо	
72		Хэмжилзүйн зөвлөл	
73			"Худалдааны газар, түүний үйлчилгээ" стандартыг шинэчлэх ажлын хэсэг
74	Нийслэлийн засаг даргын тамгын газар		Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ -2020 хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг
75			"Улаанбаатарт үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
76			"Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл" дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
77	Цагдаагийн ерөнхий газар	Тендерийн үнэлгээний хороо	
78	Гаалийн Ерөнхий Газар		Гаалийн Ерөнхий газар дээр Гаалийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн гишүүн
79	Ашигт малтмал газрын тосны газар		Шингэрүүлсэн шатдаг хийн хангамжийн норм, дүрэм, стандартын ажлын хэсэг
80	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	





81			Хүүхэд хамгааллын бодлого боловсруулах ажлын хэсэг
82	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар		Хүүхдийн эрх болон тэдний сайн сайханд бизнес хэрхэн нөлөөлж, мөн ямар арга хэмжээ авч буйг нэгтгэн харах, улмаар холбогдох хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилготой судалгааны ажлын хэсэг
83	Үндэсний статистикийн хороо	Үндэсний статистикийн хорооны зөвлөл	
84	Зээлийн Батлан Даалтын Сан	Удирдах зөвлөл	
85		Хяналтын зөвлөлийн дарга	
86	Азийн сан	Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх төсөл	
87	Монгол-Оросын найрамдлын нийгэмлэг	Тэргүүн	
88	Компанийн засаглалын үндэсний зөвлөл	Гишүүн	
89	Монгол дахь австралийн тэтгэлэгт хөтөлбөрүүд	Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулах хороо	
90	Санхүү эдийн засгийн их сургууль	Эрдмийн зөвлөл	
91	Си Жи Эф ХХК	УЗ-ийн гишүүн	
Олон улсын байгууллагууд			
92	Дэлхийн танхимуудын холбоо	Ерөнхий Зөвлөлийн гишүүн	
93	Ази номхон далайн танхимуудын холбоо	Дэд ерөнхийлөгч	
94	Торгоны замын Олон улсын худалдааны танхим	Дэд ерөнхийлөгч	

МҮХАҮТ-ын дэргэдэх бизнесийн зөвлөлүүд

(2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

№	Зөвлөлийн нэр	Хариуцсан зөвлөлийн дарга
1	Аялал жуулчлалын зөвлөл	Ш.Нэргүй "Нью Жуулчин турс" ХХК-ийн ерөнхий захирал
2	Импортлогчдийн зөвлөл	Б.Жаргалсайхан "Би Эс Би Сервис" ХХК-ийн ерөнхий захирал
3	Итгэмжлэгдсэн лабораторуудын зөвлөл	Ч.Сайнбаяр ИНЕГ-ийн лабораторийн эрхлэгч
4	Ноос ноолуурын зөвлөл	Ч.Түмэнбаяр
5	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл	А.Лувсандагва Бизнес инкубаторуудын холбооны гүйцэтгэх захирал
6	Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл	Ш.Алтанбагана "Тера Экспресс" ХХК-ийн ерөнхий захирал, Монголын маркетингийн холбооны ерөнхийлөгч
7	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл	Л.Болормаа "Би Эф Эй Си" ХХК-ны Гүйцэтгэх захирал
8	Эдийн засгийн бодлогын зөвлөл	Р.Амаржаргал Монгол Улсын Ерөнхий Сайд асан, Амаржаргал сангийн ТУЗ-ийн гишүүн /Зөвшилцсөнөөр/
9	Сэргээгдэх эрчим хүчний зөвлөл	Р.Давааням "Сайншанд Салхин Парк" гүйцэтгэх захирал
10	Хууль зүйн бодлогын зөвлөл	Т.Мэндсайхан МУИС-ын ХЗС-ийн хувийн эрх зүйн танхимын дэд профессор, МОУҮА-ын арбитрч
11	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл	С.Түмэнгэрэл "Өгөөж чихэр боов" ХХК-ийн ерөнхий захирал
12	Инноваци ба Гарааны бизнесийг дэмжих зөвлөл	Л.Оюунцэцэг Доктор, Профессор, ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Технологийн менежментийн салбарын эрхлэгч З.Билэгбаатар (орлогч) "Стартап Монголиа"
13	ОХУ-тай хамтран ажиллах зөвлөл	Д.Эрдэнэбат Монгол Улсын Их Хурлын Гишүүн УИХ Дахь АН-ын Бүлгийн Дарга
14	Хятад улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл	С.Бямбацогт УИХ-ын гишүүн
15	Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл	Ч.Амарбаатар "Барс" группын ерөнхий захирал
16	Экспортыг дэмжих зөвлөл	Д.Галсандорж Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч
17	Япон улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл	Д.Сумъяабазар -Ерөнхийлөгч Гүйцэтгэх захирал Ч.Чинзориг УИХ-ын гишүүн- Уул уурхайн яамны сайд Ч. Чинзориг - "Азумо" ложистикийн компанийн захирал
18	Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл	Зөвлөлийн ерөнхийлөгч- Ж.Энхсайхан Зөвлөлийн гүйцэтгэх захирал Цэнхэр сүлд ТББ-ын гүйцэтгэх захирал, элчин сайд асан, Фрэй Виллэ Жевелри ХХК-ний гүйцэтгэх захирал Б.Одончимэг
19	Худалдааг хөнгөвчлөх, тээвэр, ложистикийн зөвлөл	П.Солонго Азийн Зам ХХК-ийн Гүйцэтгэх Захирал
20	Франчайзингийн зөвлөл	Б.Цэцэнгауй Монголын жижиг дэлгүүрүүдийг дэмжигчдийн холбоо



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

Мэдэгдэл

Татварын хувь хэмжээг нэмэх нь зөв шийдэл биш ...

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны улсын төсөвт тодотгол хийх хүрээнд зарим татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх саналыг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэх болсонтой холбогдуулан МҮХАҮТ-аас энэхүү мэдэгдлийг гаргаж байна.

Монгол улсын засгийн газраас эдийн засаг, санхүү, валютын нөөцтэй холбоотой бодитой тоо мэдээг албан ёсоор зарлаж, эдийн засгийн хямралаас гарах гарцыг хайж, зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг бид харж байна. Эдийн засгийн хямрал 2013 оноос хойш гурван жил гаруй үргэлжилж, аж ахуйн нэгжүүд эцсийн нөөцөө шавхтал дуулгавартай, хүлцэнгүй байдлаар хүндрэл бэрхшээлийг туулж татвараа төлж ирлээ. 2016 оны "Бизнес итгэлийн индекс"-ийн үр дүнгээс харахад бизнес эрхлэх орчинд өгөх бизнес эрхлэгчдийн үнэлгээ буурсаар байна. Тухайлбал 2012 онд бизнесийн орчинг "сайн" гэсэн бизнес эрхлэгчид, иргэд 14,7 хувь байсан бол 2016 онд 8,4 хувь, "дунд" гэсэн нь 61,1 хувь байснаа 42 хувь болж буурсан ба харин "муу, маш муу" гэж үзсэн бизнес эрхлэгчид 13,1 хувь байсан бол 42,7 хувь болтлоо өсчээ.

2015 онд батлагдсан "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулиар 33 мянган аж ахуйн нэгжийн 34.2 их наяд төгрөгийн ажил үйлчилгээ, хөрөнгө ил болсон. Мөн 2016 оны 1-р сарын 1-нээс "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" шинэчилсэн хууль хэрэгжиж эхэлснээр өнгөрсөн хугацаанд кассын машины тоо 1700-аас 40 000 болж, татварын бааз суурийг 23 дахин нэмэгдүүлсэн. Үүнийг татварын орлого 99.5 хувиар буюу бараг 100 хувь биелсэн сүүлийн статистикийн мэдээнээс харж болно. Эдийн засаг зогсонги байдалд орчихсон, эргэлт байхгүй ийм үед татварын орлого ийм дүнтэй биелнэ гэдэг нь цаад утгаараа бид зах зээлийнхээ 60 хувиас авч чаддаггүй байсан татвараа шинэ системийн үр дүнд авдаг болоод байгааг харуулж байна. Ийнхүү орлого олж байгаа аж ахуйн нэгж, хувь хүн бүгд татвараа төлөх нөхцөлийг бүрдүүлэн, татварын бааз суурийг өргөжүүлснээр татварын хувь хэмжээг нэмэхгүйгээр, татварын орлогыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Ийм үед хүн амын орлогын албан татварыг 25 хувь хүртэл нэмэгдүүлэх асуудлыг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэх болсон нь маш буруу алхам гэж үзэж байна.

Сүүлийн өдрүүдэд огцом буурч байгаа төгрөгийн ханшийг тогтоохын тулд Монгол банкнаас бодлогын хүүг огцом нэмлээ. Энэ нь валютын зах зээлийг зохицуулах нэг механизм мөн боловч үнэн хэрэг дээрээ арилжааны банкууд зээл олгохгүй болох, ингэснээр бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орох, улмаар унах тал руу л түлхсэн бас нэг алхам боллоо.

Өнөөдөр татварын хувь хэмжээг нэмэх биш харин татварын тогтолцоог өөрчлөх чиглэлээр хийсэн ажлаа үргэлжлүүлэн үр дүнг нь үзэх чухал байна. Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудыг УИХ-аар батлуулах, эдгээр хуулиудыг дагалдах журмуудыг гаргаж батлах, улмаар 2017 оны 1 сарын 1-нээс татварын шинэ тогтолцоог хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Татварыг нэмэгдүүлэх, тэтгэмжийг бууруулах замаар бизнес эрхлэгчид, иргэдийн нуруунд ачааг үүрүүлэх нь эдийн засгийн хямралаас гарах зөв гарц биш юм. Макро эдийн засгийн шинэ загвар, мөнгөний шинэ бодлого гаргах шаардлагатай бөгөөд мэдлэгтэй туршлагатай баг бүрдүүлэн эдийн засгийн өнөөгийн байдлаа зөв оношлон шинэ загвар, шинэ бодлогоо тодорхойлж. Нийт бизнес эрхлэгчдийн эрх ашгийг илэрхийлэгч дуу хоолой, өмгөөлөгчийн хувьд МҮХАҮТ нь УИХ, Засгийн газар, Монгол банктай хамтран ажиллая. Бид тус тусдаа байснаар Монгол Улс, Монгол хүн бүр, Аж ахуйн нэгжүүд хямралаас гарч чадахгүй, хамтдаа хямралыг даван туулж чадна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

2016.08.26



ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН АРИЛЖААНЫ БАНК, БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ГАРГАСАН УРИАЛГА

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарсан, экспортын голлох түүхий эдийн зах зээлийн үнэ буурснаас экспортын хэмжээ буурсан, гадаадын хөрөнгө оруулалт огцом унасан, төлбөрийн тэнцэл алдагдсан, цаашлаад Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан зэргээс төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом унаж байгаа нь Монгол улсын эдийн засаг, түүний дотор бизнес эрхлэгчдэд ноцтой үр дагавар авчирч байна.

2016 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 9.6%-иар, экспорт 5.9%-иар тус тус буурлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн хэдэн жилд тасралтгүй буурч байна. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг энэ оны 8 сард S&P болон Moody's агентлагууд B2-аас B3, B-ээс /B-/ руу дараалан бууруулсан. Энэ нь манай улсад орж ирэх зээл, бондын хүү нэмэгдэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт хумигдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол банкнаас валютын ханшийг тогтворжуулах зорилгоор бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 15 хувьд хүргэж, удаа дараалан интервенц хийж байгаа ч үр дүнд хүрсэнгүй. Энэ оны 10 сард Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн дундаж 2307.80 төгрөг болж, өмнөх сараас 2.8 хувь буюу 64 орчим төгрөгөөр буурлаа. Түүгээр ч зогсохгүй 11 сарын 11-нд валютын зах дээр ам.долларын ханш 2710 төгрөгт хүрч огцом савлагаа гарсан.

Төгрөгийн ханшны огцом уналтаас шалтгаалан бизнес эрхлэгчид, ялангуяа валютын зээлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүгийн зардал огцом өсч, валютын ханшны эрсдэлийг удирдах боломжгүй болсноос сөхрөхөд хүрч байна.

Энэхүү байдал цааш улам даамжирвал Монгол улс дампуурлын ирмэгт тулахыг эдийн засагт оролцогч бүх талууд сайн мэдэж байгаа. Банк санхүүгийн байгууллагууд ба зээлдэгч аж ахуйн нэгжүүд, аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо хамтдаа зөв гарцыг олж, хүндрэлээс хамтдаа гарна. ГАРЦ:

· *Иргэний хуулийн 218 дугаар зүйлийн 1 дэх заалтанд Төлбөр гүйцэтгэх мөнгөний ханш: “Төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсэх үеийн ханшаар тооцож төлбөрийг төлнө” гэж заасан.*

· *Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг “хүнд нөхцөл байдал” (hardship) буюу эдийн засгийн урьдчилан таамаглах боломжгүй өөрчлөлтийн улмаас гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдал гэсэн нэгдсэн ойлголт байдаг.*

Иймд МҮХАҮТ-аас иргэний хуулийн энэхүү заалтыг нэг зарчмаар ойлгож хэрэглэх, мөн “хүнд нөхцөл байдал”-ын улмаас гэрээний үүргээ биелүүлэх хариуцлагаас чөлөөлөгдөх боломж байгааг зохих ёсоор хэрэгжүүлэхийг арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд ба аж ахуйн нэгжүүдэд уриалж байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

2016.11.18



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ОУВС-ИЙН ӨРГӨТГЭСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛСОНТОЙ ХОЛБОГДУУЛАН МҮХАҮТ-ААС УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА, ГИШҮҮДЭД ХАНДСАН

МЭДЭГДЭЛ

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, НӨАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2016 оны төсвийн татварын орлого төлөвлөснөөс 487,1 тэрбум төгрөгөөр түүний дотор нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 70.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба сүүлийн 20 жилд анх удаа татварын орлого бүх төрлөөр биелсэн байна. Мөн 2017 оны эхний 3 сард татварын орлого 30%-иар давж биеллээ. Үүнээс дүгнэхэд татварын эрх зүйн орчны шинэчлэлийн системийн эхлэл тавигдаж, үр дүнд нь эдийн засаг хүндрэлтэй байгаа хэдий ч төсөвт төвлөрөх татварын орлого зөвхөн 2016 оны 1 сарын 1-нээс өнөөдрийг хүртэлх хугацаанд 800 тэрбум төгрөгөөр давсан байна.

Ийнхүү татварын суурь өргөжиж, татварын орлого бүрдүүлэхэд нааштай үр дүн гарч байгаа энэ үед Засгийн газраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх, тэтгэврийн насыг нэмэх, түүнчлэн 2016 оны намрын чуулганаар хэлэлцүүлж байсан татвар нэмэх асуудлыг Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжүүлэх нэрийн дор 2017 оны төсвийн тодотголтой хамт УИХ-д өргөн барьж байгаатай холбогдуулан бизнесийн төлөөллийн гол байгууллагын хувьд МҮХАҮТ дараах санал, шаардлагуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Төсвийн зардлыг 2017 оны батлагдсан төсвөөс огт нэмэгдүүлэхгүй байх. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тодотголоор нийт зарлага ба цэвэр зээлийг батлагдсан түвшнээс 220.7 тэрбум төгрөгөөр нэмсэн байна;
2. Төрийн захиргааны албан хаагчдийн тоог 20 %, үйлчилгээний албан хаагчдийн тоог 10%-иар тус тус бууруулах. 2012 оноос хойш төрийн албан хаагчдийн тоо ойролцоогоор 15 хувь буюу 24 мянгаар өссөн байна. Мөн төрийн албан хаагчдийн шаардлагагүй зардал, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг зогсоох;
3. Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэхгүй байх. Эдийн засаг хямралтай, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого буурсан хүнд нөхцөл байдалд НДШ-ийг нэмэгдүүлэх нь ажлын байр буурах, улмаар ядуурал ихсэх нөхцөл болно;
4. Хувь хүний орлогын албан татварыг нэмэгдүүлэхгүй байх;
5. Тодорхой салбарт дэмжлэг үзүүлэх, зарим барааны үнэ тогтворжуулах нэрийн дор зах зээлийн зарчмаар тэгш, шударга өрсөлдөх боломжийг хааж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлэхгүй байх;
6. Онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүй байх;
7. Төсвөөс татаас авдаг, алдагдал өндөртэй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, татан буулгах асуудлыг яаралтай шийдвэрлэх;
8. Тэтгэврийн насыг үе шаттай нэмэх асуудалд тооцоо, судалгаатай хандан шийдвэр гаргах. Энд баталгаатай ажлын байртай төрийн 183 мянга гаруй албан хаагчдийн тэтгэврийн насыг нэмэх асуудлыг төр өөрөө мэдэж зохицуулах боломжтой ч чөлөөт зах зээлд ажиллаж байгаа 1 сая гаруй иргэд баталгаагүй, тогтворгүй ажлын байранд ажилладаг гэдгийг онцгойлон анхаарах шаардлагатай. Мөн монгол хүний насжилт, салбарын онцлог, ажлын байрны нөхцөл, тогтвортой байдал зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэх хэрэгтэй.

Иймд Улсын Их Хурал 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган дээрх шаардлагуудыг судлан шийдвэрлэхийг УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын эрхэм гишүүдээс шаардаж байна.

Бизнес эрхлэгчдээс тавьж байгаа эдгээр шаардлагуудыг хүлээн авч нааштай шийдвэрлээгүй тохиолдолд 2017 оны 4 сарын 10-нд төлөх 3 дугаар сарын Нэмэгдсэн өртгийн албан татвар, 4 сарын 15-нд төлөх 1 дүгээр улирлын ААНОАТ, 5 сард төлөх 4 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байхыг нийт аж ахуйн нэгжүүдэд уриалахаа мэдэгдэж байна.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2017.04.05



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

УРИАЛГА

Монгол улсад нүүрлээд байгаа улс төрийн намуудын дотоод зөрчил нь Монгол төрийн тогтвортой байдлыг алдагдуулахад хүрч улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах, валютын ханш болон гадаад худалдааны алдагдал өсөх ноцтой үр дагаварт хүргэхээр байна. Сүүлийн жилүүдэд Засгийн газрын өрийн хэмжээ өсч, улсын төсвийн алдагдал нэмэгдсэн нь эдийн засагт ихээхэн дарамт болж эдийн засаг саарахад хүргэлээ. Эдийн засгийн хямралтай байгаа ийм үед энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн зарим үзүүлэлтүүд эерэг дүр зурагтай гарсан нь бизнес эрхлэгчдийн хувьд бага ч атугай найдварыг төрүүлсэн юм.

Хямралтай эдийн засгийг хөгжлийн зөв бодлогоор удирдан залж, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр тогтвортой өсгөх үүрэгтэй Төр, засаг нь өнгөрсөн 25 жилд дунджаар 1.7 жилийн хугацаатай 14 гүйцэтгэх засаглалтай байж, төрийн залгамж халаа алдагдаж, бодлогын хувьд харилцан уялдаагүй ажиллалаа. Өнөөгийн улс төрчдийн хариуцлагагүй үйлдлээс болж бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид өөрсдийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх улмаар татвар, шимтгэл төлөхөд ихээхэн хүндрэлтэй болж байна.

Бизнес эрхлэгчид өнөөдрийг хүртэл Засгийн газрын боловсруулсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” болон эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрээс тодорхой, эерэг үр дүнг хүлээсээр байлаа.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь бизнес эрхлэгчдийн дуу хоолой илэрхийлэгчийн хувьд Төрийн эрх баригчдаас өөрсдийн үүрэг, хариуцлагыг ухамсарлан, улс орны хөгжлийг нэн тэргүүнд тавьж, ТОГТВОРТОЙ, ЧАДВАРЛАГ ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛТАЙГААР ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ ОНОВЧТОЙ БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОН, БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХАМТРАН ТУУШТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ уриалж байна.

МҮХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2017.09.15



МҮХАҮТ-ААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ, АЖЛАА ЭРЧИМЖҮҮЛЭХИЙГ УРИАЛСАН УРИАЛГА

Монгол Улсын Засгийн газраас ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасантай холбогдуулан 2017 оны 4 сард МҮХАҮТ-аас төсвийн зардлыг багасгах, төрийн албан хаагчдын тоог бууруулах, ХАОАТ, НДШ, Онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүй байх шаардлага бүхий МЭДЭГДЭЛ-ийг гаргаж, уг асуудлаар УИХ-ын дарга М.Энхболд Танхимын удирдлагууд болон бизнес эрхлэгчдийн төлөөллийг хүлээн авч уулзсан. Уулзалтаар нийт 8 асуудлыг зөвшилцөж, мэдэгдлийн мөрөөр авах арга хэмжээнүүдийг тохиролцон, хоёр талаас авч хэрэгжүүлсэн билээ.

МҮХАҮТ-аас ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” ба хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний үр нөлөө болон бизнесийн орчны нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг бодлого боловсруулах түвшинд хүргэх зорилгоор олон уулзалт, хэлэлцүүлэг хийж, удаа дараа уриалга, мэдэгдлийг өнгөрсөн хугацаанд гаргаж ирсэн. Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны 100 хоногоо дүгнэж, энэ үеэр ОУВС-тай ахин хэлэлцээр хийж, бизнес эрхлэгчид ба иргэдийн саналыг хүлээн авч, ХАОАТ-ын нэмэгдлийг хүчингүй болгох, Онцгой албан татварыг тэглэх зэрэг бизнес, хөрөнгө оруулалтын орчинд эерэг нөлөө үзүүлэх шийдвэр гаргасанд нийт бизнес эрхлэгчдийн өмнөөс МҮХАҮТ талархал илэрхийлж байна.

Эдийн засаг сэргэх хандлага гарч байгаа энэ үед Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагч болон нийгмийн халамжид чиглэсэн төсвийн зарцуулалтыг багасгах, аливаа салбарыг дэмжсэн өгөөж, үр ашиг муутай элдэв сан, хөтөлбөрийг цөөрүүлэх, цэгцлэх, татаасыг бууруулах, алдагдалтай ажиллаж буй ТӨХК-уудыг хувьчлах мөн төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлээс бараа, үйлчилгээ нийлүүлэх эрх зүйн орчныг улам сайжруулах, бизнес эрхлэгчдийг татварын хураалтад тэгш, шударга хамруулж, татварын суурийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний шударга орчныг бий болгох зэрэг бодлогын эрс шинэчлэлийг нэн яаралтай хэрэгжүүлж эхлэх, бодит үр дүн гарган ажиллахыг бизнес эрхлэгчид хүлээж байна. Нэн ялангуяа Монгол Улсын Засгийн газраас Татварын багц хуулийг УИХ-д өргөн барьж, хаврын чуулганаар хэлэлцүүлэн, батлах шаардлагатай байгаа бөгөөд үүнд МҮХАҮТ бүх үе шатанд нь нягт хамтран ажиллах болно.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2018.02.01



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

МЭДЭГДЭЛ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Чуулганаар дахин хэлэлцэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Чуулганаар татварын шинэчлэлд онцгой ач холбогдолтой Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн үзэл баримтлалыг хэлэлцээд УИХ-ын гишүүдийн олонх нь бизнес эрхлэгчдэд маш их хүлээлт үүсгэсэн тус хуулийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэн, буцаах шийдвэрийг гаргасан нь татварын шинэчлэлийн эсрэг, одоог хүртэл хийсэн татварын шинэчлэлийн ач холбогдлыг үгүй хийсэн алхам боллоо.

ААНОАТ-ын тухай хуулийн төсөлд ААН, бизнес эрхлэгчдийг татвар төлөлтөд жигд хамруулах, гадаадын ААН-д татвар ногдуулах, татварын суурийг өргөтгөх, улсын төсөвт нөлөөлөх зэрэг заалт оруулснаас гадна 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй албан татвар төлөгчид татварын хөнгөлөлт үзүүлэх, цаашлаад ААН, арилжааны банкнуудын гадаад зах зээлээс оруулж ирэх валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өртөг хямдрах, хөрөнгө оруулалтыг дэмжих, үүнд суурилж зээлийн хүү буурах, бага хүүтэй зээл олгох зэрэг олон таатай боломжууд бүрдэх заалтууд туссан байсан бөгөөд эдгээр нь бизнес эрхлэгчдийн зүгээс дэмжлэг авсан юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай Улсын ДНБ 5.4, мөнгөний нийлүүлэлт 6.5, татварын орлого 4.1, ААНОАТ-ын орлого 4.3, ХХОАТ-ын орлого 9.2 дахин нэмэгдэж, мөн энэ хугацаанд инфляци дунджаар 10 хувь байж, бараа, үйлчилгээний үнэ 286.24 хувиар өссөн статистик байна. Мөн ААНОАТ-ыг голлон төлдөг 398 байгууллага байдаг бөгөөд 2007 оноос мөрдөгдөж байгаа тус хуулийн 3 тэрбумын татварын шатлал нь ААН-ийг татварын дээд шатлалд орохоос зайлсхийн олон жижиг компани байгуулах, ажлын байрыг бууруулах, өрсөлдөх чадваргүй болоход нөлөөлсөөр байна. Энэ нь татварын орчныг эдийн засгийн нөхцөл байдал, компанийн өсөлттэй уялдуулан, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, үр ашигтай, хөрөнгийн төвлөрөлтэй, өрсөлдөх чадвар бүхий ААН бий болгох зорилгоор татварын шатлалын босгыг 6.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх зэрэг эрс шинэчлэл, өөрчлөлт хийх шаардлагатай чухал хуулийн төсөл юм.

Иймд эдийн засаг сэргэх нааштай өөрчлөлтүүд бий болж байгаа өнөөгийн нөхцөлд 2007 оноос хойш мөрдөгдөж буй тус хуулийг шинэчлэх шаардлагатай болсонд онцгой анхаарал хандуулж, УИХ-ын дарга, эрхэм гишүүд Та бүхэн Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийнхээ дагуу, өөрсдийн үүргийг ухамсарлан тус хуулийн үзэл баримтлалыг хэлэлцэн, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлгийн шатанд хийж, бусад хуулийн төслүүдтэй хамт хэлэлцэн, батлахыг шаардаж байна.

МУХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2018.06.15



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ ТАНАА

МЭДЭГДЭЛ

Төрийн хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, Нийтийн санхүүгийн ил тод байдлыг хангах тухай

ЖДҮХС-гаас төр засгийн өндөр албан тушаалтнууд өөрсдийн эрх мэдэл, давуу байдлаа ашиглан хувийн компаниуддаа зээл авсан нь ил болж, олон нийтийн бухимдлыг төрүүлж байгаа энэхүү үйл явдлыг бизнес эрхлэгчдийн дуу хоолой болох МҮХАУТ ихэд жигшин зэвүүцэж байна.

Энэ нь зөвхөн ЖДҮХС хэмээх ганц сангаар дамжсан зүй бус зарцуулалтаар илэрч байгаа хэдий ч Монголын төрд урхагшсан хариуцлагагүй байдал, хяналтгүй зарцуулалт, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм хуульзүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, иргэддээ зах зээлийн тэгш боломж олгохтой холбоотой Үндсэн хуулийн хэд хэдэн зүйл, заалтыг зөрчиж байгаа явдал юм.

Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7-д улсын төсвийн бүх зардал УИХ-ын онцгой эрхээр зохицуулагдана хэмээн заасан ч манай эрх баригчид ард иргэдийнхээ өмнө ил тод, шударга байх үүргийг умартаж, татварын хөрөнгөөр сан нэртэй "мөнгө угаалт"-ыг санхүүжүүлж, хяналтгүйгээр ашиглаж байгаа нь эдийн засгийг эвдэж, зах зээлд тэгш оролцох зарчмыг алдагдуулж байгаа хэрэг гэж үзэж байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засагт хямралын дараах нааштай нөхцөл байдал үүсч, татварын орлого нэг их наядаар давж биелэн, макро түвшинд бизнесийн орчин харьцангуй таатай болж байгаа ч энэ нь нийт аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, хувийн хэвшлийнхний шаргуу хөдөлмөрөөр бий болсон үр дүн юм.

Бизнес эрхлэгчид эскпортод бараа бүтээгдэхүүнээ гаргах, үйлдвэрлэлдээ нэмүү өртөг шингээх зэргээр цуцалтгүй хөдөлмөрлөж, татвараа шударгаар төлж, бизнесийн өрсөлдөөнд өндөр эрсдэл үүрэн зүтгэж байхад нөгөө хэсэг болох төрийн өндөр албан тушаалтнууд бизнесийг дэмжих ёстой сангуудын хөрөнгийг өөрсдийн эрх мэдэл, давуу байдлаа ашиглан ямар ч хяналтгүй завшиж байгааг байж болшгүй явдал гэж үзэж байна.

Үндсэн хуулийн 5.1-т Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж заасан байдаг ч нийтийн санхүүг төрийн эрх мэдэлтнүүдээс хамгаалах нарийвчилсан хяналт, хамгаалалт байхгүй тул энэ чиглэлд эрхзүйн зохицуулалт бий болгоход бизнес эрхлэгчдийн зүгээс дуу хоолойгоо илэрхийлж хамтран ажиллахад бэлэн байна.

Энэ мэтээр санхүүгийн систем дэх ил тод байдлыг бүрдүүлж, нийтийн санхүүгийн зарцуулалт, хуваарилалтыг шударга, хүртээмжтэй болгох үүднээс Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, ЖДҮХС болон бусад 27 сангийн зарцуулалт, санхүүгийн тайлан, холбогдох шийдвэрүүдэд хяналт тавих хөндлөнгийн Мэргэжлийн багийг томилох, үйл ажиллагааг нь ил тод болгож нийтэд мэдээлэх, Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Бондын асуудлыг ойрын хугацаанд дүгнэж хариуцлага тооцох зэргийг бизнес эрхлэгчдийн зүгээс шаардаж байна.

Мөн мал аж ахуйн болон газар тариалангийн гаралтай түүхий эдээ дотооддоо боловсруулж нэмүү өртөг шингээн үндэсний үйлдвэрээ төрөлжүүлэн хөгжүүлэх, тэдний өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн зорилго бүхий эдийн засгийн гол хуулиуд болох Татварын багц хуулиуд, ЖДҮ-ийн хуулиудыг УИХ-аар яаралтай батлахыг шаардаж байна.

Эдгээр шаардлагуудыг үл биелүүлбэл бизнес эрхлэгчид өөрсдийн дуу хоолойгоо эрчимтэй илэрхийлсээр байх төдийгүй татвараа өнөөг хүртэл шударгаар төлж ирсэн итгэл үнэмшил, хуулиар хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн биелүүлэхээс татгалзаж, тэмцлийн дараагийн хэлбэрт шилжих болно гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

МҮХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2018.11.12



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

МЭДЭГДЭЛ

Төр, Засгаас авлига болон аливаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажлаа бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтөнд сөрөг үр дагаваргүй хийхэд онцгой анхаарах,

Улсын Их Хурал дээр гацаад байгаа бизнестэй холбоотой хуулиудыг хэлэлцэн батлахыг шаардах тухай

Монгол Улс чөлөөт зах зээлийн нийгэмд шилжин, компани гэх шинэ институцтэй болж, ганц Төр бус олон мянган компаниуд ажлын байрыг бий болгон, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрийг оруулж байна. 1991 онд "БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль" батлагдаж хэрэгжсэний үр дүнд 1995 оны байдлаар 466 хувьцаат компани, 1297 бүрэн бус хариуцлагатай компани, 1907 хоршоо, 850 хувиараа эрхлэх аж ахуй бий болсон бол 2018 оны байдлаар бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 167 мянга болж, 1991 онтой харьцуулахад 37 дахин өсч, 1.2 сая гаруй иргэнийг ажлын байраар хангаж байна. Татварын орлого 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8.2 их наяд хүрсэн нь төлөвлөснөөс 29 хувь буюу 1.8 их наядад давсан бөгөөд үүний дотор ААН-ийн орлогын албан татвар өмнөх оныхоос 32 хувиар нэмэгдсэн байна.

Хувийн хэвшлийн эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр улам бүр өсч байна. Монгол Улсын Засгийн газраас МҮХАУТ-тай хамтран зарладаг ТОП-100 ААН-үүд дангаараа 27 их наяд буюу ДНБ-ийн 94 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 80 гаруй нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байна. Өөрөөр хэлбэл мянга, мянган аж ахуй нэгжүүд, тэдгээрт ажиллагсдын хүчээр Монгол Улсын эдийн засагт тодорхой нөлөө бүхий компани гэсэн институци бий болж, хөгжиж, зарим нь олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, гадаад зах зээлд байр сууриа эзлэхэд бэлэн болжээ. Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын тааламжтай орчин, шударга өрсөлдөх нөхцөл боломжоор ханган, олон улсын өртгийн сүлжээнд нэгдэх, олон улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө босгоход нь бодлогоор дэмжиж өгөх нэн шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурал 2018 оны намрын ээлжит чуулганы нээлтийн үеэр иргэн бүрд хүртээмжтэй өсөлтийг бий болгохын тулд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, бизнесийн орчныг сайжруулан ажиллахаа илэрхийлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарлан, энэ хүрээнд мөн л ил тод байдал, иргэний оролцоотой шийдвэр гаргах гэсэн зорилт тавилаа. Ийнхүү бизнес эрхлэгчдийг дэмжих талаар ярьж байгаа ч хэрэг дээрээ улс төрийн маргаантай байдал үргэлжилсээр ямар ч хууль хэлэлцэн батлагдахгүй чуулган завсарлах болж байна. Эдийн засгийг сэргээх арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн авах шаардлагатай байгаа энэ эмзэг үед улс төрийн намууд хооронд, намын доторх зөрчил тэмцэл нь Төр, Засгийн байр суурь хүчтэй ганхахад хүргэж байгааг олон нийтээрээ харж байна. Эцэстээ улс төрийн энэ зөрчил тэмцэл хувийн компаниудын эрхэд халдаж, бизнесийн нэг хүрээллээс нөгөө хүрээлэл рүү дайрах зэвсэг болгож, хувийн хөрөнгө оруулалтад хуулийн дагуу бус хүч түрсэн шийдвэр, үйлдэл гаргахад хүргэж байна.

Монгол Улс 2013-2016 онуудын эдийн засгийн хямралыг арай ядан давж, сэргэлт ажиглагдаж эхэлсэн энэ үед Төр, Засгаас авлига, аливаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажлаа бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтөнд сөрөг үр дагаваргүй хийхэд онцгой анхаарах; Улс төрийн сонгуулийн өмнөх төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, халамжийг хавтгайруулах бодлого, үйлдлээ зогсоох; Төрийн өмчит компаниудыг улс төрчдөөс ангид байлгаж, хувьцаат компани болгох; Төрийн нийтийн хамааралтай өмчийг ашиглан бизнесийн үйл ажиллагаа явуулах, Засгийн газар, бизнесийн байгууллага ба иргэний харилцааг тодорхой болгох; Төрийн нийтийн хамааралтай өмчид оруулж буй хөрөнгө оруулалт нь улс төрийн ба эрх зүйн талаасаа эрсдэлгүй байх нөхцөлийг бий болгох; Төрийн сангуудын зарцуулалтад олон нийтийн хяналттай, зөв тогтолцоог бүрдүүлэх; УИХ дээр гацаад байгаа бизнестэй холбоотой хуулиудыг хэлэлцэн батлах зэрэг олон ажил хүлээгдэж байгааг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газарт нийт бизнес эрхлэгчдээс анхааруулж байна.

МҮХАУТ-ын Удирдах зөвлөл, Тэргүүлэгчид

2019.01.24



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

МЭДЭГДЭЛ

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан,

Татварын багц хуулийн төслийг хэлэлцүүлэх тухай

Бизнес эрхлэгчдийн зүгээс өнгөрсөн намрын чуулганаар Улсын Их Хурлын гишүүдийг татварын шинэчлэлд онцгой ач холбогдол өгч, Татварын багц хуулийн төслийг хэлэлцэж, батлагдахыг ихээхэн хүлээсэн боловч, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан, хойшилсонд сэтгэл дундуур байна.

МҮХАҮТ нь өнгөрсөн 2 жилийн хугацаанд татварын эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийг татвар төлөлтөд жигд хамруулахад анхааран Монгол Улсын Засгийн газартай хамтран Татварын багц хуулийн төслийн хэлэлцүүлгүүдийг хийж, "Монгол Улсын Татварын тогтолцооны шинэчлэл, татварын оновчлол судалгаа"-г гаргаж, цаашлаад бизнес эрхлэгчдийн саналыг нэгтгэн бодлого боловсруулагч нарт хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар УИХ-ын Төсвийн Байнгын хорооны Татварын багц хуулийг УИХ-ын чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсэгт ажиллаж байна.

Татварын орчны шинэчлэлийн ажлыг 2007 онд 4/10-ын шатлалаар эхлүүлж, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай, НӨАТ-ын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай зэрэг хуулиудыг батлан хэрэгжүүлснээр татварын суурь бааз бүрдэх эхлэл болсон. 2018 онд бизнес эрхлэгчид улсад 8.2 их наяд төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлж, төлөвлөснөөс 29 хувь буюу 1.8 их наядаар давж биелүүлсэн байна. Мөн ААНОАТ-ыг өмнөх оныхоос 33 хувь, ХХОАТ-ыг 22 хувиар давж төвлөрүүлж, нэгдсэн төсвийн тэнцэл сүүлийн 8 жилийн хугацаанд анх удаа ашигтай гарлаа. Энэхүү татварын шинэчлэлийн ажлыг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд Татварын багц хуулийн төслийг батлах ажил үлдлээ.

Татварын багц хууль, тэр дундаа ААНОАТ-ын тухай хуулийн төсөлд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг татвар төлөлтөд жигд хамруулах, жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс доош бол татварын хөнгөлөлт үзүүлэх, тайланг цөөрүүлэх, орлогын татвар ногдуулах босгыг 6.0 тэрбум төгрөг болгох, гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах зэрэг эрс шинэчлэл, өөрчлөлт хийх олон таатай заалтуудыг тусгасанд бизнес эрхлэгчдийн зүгээс ихээхэн дэмжиж байгаа болно.

Монгол Улсын Засгийн газраас МҮХАҮТ-тай хамтран татварын багц хуулийн төслийг олон удаа бизнес эрхлэгчдэд танилцуулж, хэлэлцүүлсэн. Хамгийн сүүлд буюу 2 дугаар сарын 18-ний өдөр УИХ-ын Байнгын хорооны ажлын хэсэг МҮХАҮТ-тай хамтран Татварын багц хуулийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ үеэр оролцсон бизнесийн том, жижиг, дунд аж ахуйн нэгжийн төлөөлөл хүлээлт үүсгээд байгаа тус хуулийг яаралтай хэлэлцэн батлахыг дахин шаардсан. Иймд УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан, Татварын багц хуулийг хэлэлцүүлж, араас нь гарах 40 гаруй дүрэм, журмуудад яаралтай өөрчлөлт оруулж, эхлүүлэх хэрэгтэй байна.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2019.02.25







Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 101011001

Утас: +976-11-310619

Факс: +976-11-324620

e-mail: policy@mongolchamber.mn

www.mongolchamber.mn